

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 71
1.	<i>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох</i>	7 – 57
2.	<i>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх</i>	57 – 71

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Номинчимэг, Ч.Ундрэм;

Чөлөөтэй: Б.Батцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Галбадрах, Х.Жангабыл;

Тасалсан: Ж.Батсуурь, Х.Баттулга, С.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр хэлэлцэх асуудлын дарааллын хоёрт орсон Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын асуудлыг хэлэлцэх асуудлын эхэнд хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 10

Бүгд: 15

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Нэг.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Мэдээллийн технологи, системийн шинжилгээний газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, мөн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн референт Н.Лхам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч И.Давааноров, Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн Шийдвэрлэлт хариуцсан менежер М.Үүрийнтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Иргэн, хуулийн этгээдээс Засгийн газарт хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Д.Батбаяр, О.Саранчулуун, Д.Ганмаа, Л.Мөнхбаясгалан, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч И.Давааноров нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Ж.Золжаргал, Д.Батбаяр, О.Саранчулуун, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч С.Жаргалсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч Э.Цэрэнбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц хариуцсан мэргэжилтэн Б.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах асуудлаар ирүүлсэн ахмадуудын өргөдлийг судлан санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ө.Шижир нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд нар хариулж, тайлбар хийв.

Х.Баасанжаргал: Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах талаар ахмадуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, шаардлагын дагуу өргөдөл гаргагчдад хариу хүргүүлэх асуудлыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал дараагийн өргөдлүүд нь хувь хүний хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдлүүд учраас Байнгын хорооны хуралдааныг хаалттай горимоор явуулъя гэсэн горимын санал гаргав.

Х.Баасанжаргал: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 7

Бүгд: 16

56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хаалттай горимоор хэлэлцэхээр тогтов.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 27 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Баасанжаргал: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Өргөдлийн байнгын хорооны ээлжит хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учраас хуралдаан албан ёсоор нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Хуралдаанд Хүрэлбаатарын Баасанжаргал, Далайн Батбаяр гишүүн 5 дугаар тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн 4 дүгээр тойрог, Жанчивын Галбадрах гишүүн өвчтэй, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн 9 дүгээр тойрог, Ганзоригийн Лувсанжамц, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн 7 дугаар тойрог, Пүрэвбаатарын Мөнхтулга 1 дүгээр тойрог, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун гишүүн, Мягмардашийн Сарнай, Чинбатын Ундрам 5 дугаар тойрог, Саруулсайханы Цэнгүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гэсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр Байнгын хорооны хуралдаан 56 хувийн хуралдааны ирцтэйгээр хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэдийгээр Та бүхний гар дээр хоёр хэлэлцэх асуудал гэж байгаа ч гэсэн яг иргэн болгоноос ирсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх үед бид санал хураалт байгаа. Нийтдээ 29 санал хураалт байгаа.

Тийм учраас манай гишүүд идэвхтэй оролцоосой гэж хүсэж байна.

Эхний асуудлыг хэлэлцэж дууссаны дараа бүгдээрээ зарчмын томъёоллоор санал хураалт явагдана гэдгийг урьдчилаад гишүүддээ сануулаад хэлэх гэсэн юм.

Дараах хоёр хэлэлцэх асуудал байгаа.

Нэгдүгээрт, Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсоно.

Хоёрдугаарт, Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдон Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байгаа юу? Далайн Батбаяр гишүүн.

Далайн Батбаяр гишүүний микрофоныг нээнэ үү.

Д.Батбаяр: Баярлалаа. Энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүддээ тэгээд чухал асуудал хэлэлцэх гэж байгаа учраас ирсэн өргөдөл, гомдлуудыг нь эхэлж хэлэлцүүлье.

Хэлэлцэх асуудлыг нэгдүгээрт нь оруулж өгөөч ээ гэсэн саналтай байна.

Х.Баасанжаргал: Байрыг нь сольё. Тийм ээ. Гэхдээ энэ дээр хэдүүлээ юу яая тэгэх үү. Эхний асуудал буюу Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсох буюу яг холбогдох ажлын хэсгийн гишүүд ирсэн байгаа. Төрийн албанд албан хаагчид гэсэн үг. Тийм ээ.

Дараа нь бид тэр 29 иргэдийн өргөдөл, гомдолтой танилцаад хурлаа хаалттай хэлбэр лүү шилжүүлэх горимын санал гаргах юм.

Тэгэхээр ер нь бид эхлээд төрийн албан хаагчдаа 2.30-аас хойш бүтэн цаг гаран хүлээлгэсэн учраас хэдүүлээ эхлээд өргөдөл, гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх мэдээллээ сонсчихоод дараа нь 20 хэдэн өргөдөл гэдэг чинь зүйл байгаа. Тэрийгээ тэгээд тэр дундаа хаалттай горим руу шилжүүлэх учраас байрыг солихгүй байвал ямар вэ гэдэг тийм тайлбарыг хэлж байна гэсэн үг. Тийм. Тэгье. Санал хураана. Гэхдээ би тайлбар хэлээд тэгээд санал хураалт явуулъя.

Хэлэлцэх асуудалтай холбоотой Далайн Батбаяр гишүүний гаргасан саналын дагуу санал хураалт явуулъя.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг хэлэлцэх асуудлын Хоёрдугаарт хэлэлцүүлье гэдэг саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлтгэнэ үү. Санал хураалт эхэлье. /алх цохив/

Нийтдээ 6 гишүүн буюу 33.3 хувь зөвшөөрсөн.

Бүгдээрээ хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын
мэдээллийг сонсох**

Нэгдүгээр асуудал. Иргэн, хуулийн этгээдээс Засгийн газарт хандан гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын мэдээллийг сонсьё.

Мэдээллийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг танилцуулна.

Б.Батцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр бид Монгол Улсын Засгийн газарт иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг 2025 оны гуравдугаар улирлын байдлаарх мэдээллийг танилцуулах гэж байна.

Монгол Улсын Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг 2023 онд байгуулсан. Байгуулагдсан цагаасаа хойш Засгийн газарт иргэд болон аж ахуйн нэгжээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлыг хагас, бүтэн жилээр үр дүнг танилцуулах, тандан судалгаа хийх чиг үүргийг манай байгууллага хэрэгжүүлээд ажиллаж байна.

Тэгэхээр өнөөдрийн миний Та бүхэндээ танилцуулах гэж байгаа мэдээллийн гол агуулга иргэдээс төрийн төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын мэдээлэл, Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар анх удаа Монгол Улсад өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээлэл гаргах, хүргүүлэх журам Засгийн газар дахь Хяналтын тухай хуулиар батлах үүргийг Эдийн засаг, хөгжлийн сайдад өгсөн.

Энэ журмын зохицуулалт. Мөн нэгдсэн сангийн мэдээлэл орж ирж байгаа.

Ерөнхий сайд Г.Занданшатар сайдаас үүрэг болгосны дагуу төрийн байгууллага дээр ирж байгаа нийт мэдээллийн нэгдсэн санг бүртгэх,

хөдөлгөөнийг нь хянах, шийдвэрлэлтэд нь хяналт тавих мэдээллийн санг бид ажиллагаанд оруулах гэж байна. 2026 оноос. Энэ мэдээллээр өгнө.

Цаг амжвал би иргэдээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг илүү тодорхой агуулгаар нь танилцуулна.

Манай байгууллагын бүтцэд мөн 11-11 гээд иргэд, олон нийттэй харилцах төв ажилладаг. Үүн дээр ирсэн иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг нэгтгэн 2025 оны гуравдугаар улирлын байдлаар танилцуулах гэж байна.

Тэгээд дүгнэлт, саналаа танилцуулна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль бидний үйл ажиллагаандаа мөрдөж байгаа үндсэн хууль 1995 онд батлагдсан.

Түүнээс хойш Засгийн газрын 67 дугаар тогтоол 2005 онд батлагдаж, шийдвэрлэлтийн тайлагнах асуудлыг Засгийн газрын тогтоолд тусгасан байдаг.

Түүний дараа 2022 оны 11 дүгээр сард Засгийн газар дахь хяналтын тухай хууль батлагдаж, иргэдийн өргөдөл, гомдол дээр тандан судалгаа хийх, үр дүнг тайлагнах, шийдвэрлэлтийг хянах асуудлуудыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар дээр үүрэг өгөөд энэ үйл ажиллагаа явагдаж байгаа.

Мөн Засгийн газар дахь хяналтын тухай хуулиараа иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу бид хянан шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тэгээд үндсэндээ 38 субъектээс буюу 16 төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг, 22 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлуудыг нэгтгэж хагас, бүтэн жилээр Засгийн газрын хуралдаанд танилцуулдаг.

Байгуулагдсанаасаа хойших хугацаанд 4 удаагийн тэмдэглэл, өргөдөл, гомдлын тайлан мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллажээ.

Өнөөдрийн мэдээллүүдийг багц мэдээлэл болгож өгөхөөр зорьж 2023 оноос хойших ер нь өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хөдөлгөөний байдлыг энд Та бүхэнд тоон мэдээллээр харуулж байна.

2023 оны оны эцэс, 2024 оны эцэс дандаа иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлын мэдээлэл буурсан үзүүлэлттэй байгаа.

2025 оны гуравдугаар улирлын байдлаар нийт төрийн захиргааны байгууллага дээр 129 мянга 349 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Та бүхэнд харуулж байгаачлан шийдвэрлэлтийн хувь өндөр хувьтай явж байгаа.

Тэгэхээр миний дараа дараагийн слайд дээр гарна. Байгууллагуудын шийдвэрлүүлэлтийн хувиуд маш өндөр явж байгаа. Гэвч иргэдийн сэтгэл ханамж буцаад иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж байгаа байдал дээр үндсэн хэрэглэгчид буюу иргэдийн сэтгэл ханамж ямар байсан талаар илүү дараа дараагийн слайд дээр үзүүлнэ.

Тэгэхээр өргөдөл, гомдлын хэлбэрийг аваад үзэх юм бол 3 жилийн хугацаанд 2 бүтэн жил, жилийн эхний гуравдугаар улирлын байдлаар 1 сая 82 мянга 664 өргөдөл, гомдол төрийн байгууллага дээр бүртгэгдсэн байна.

Үүний 62.7 хувь нь хүсэлт эзэлж байгаа.

- санал 4.19 хувь,
- гомдол 20.96 хувь,
- мэдэгдэл, талархал 12.1 хувь эзэлж байна.

Иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлыг аваад үзэх юм бол биеэр ирүүлж байгаа өргөдөл, гомдлын тоо харьцангуй бусад хэлбэрээр авч байгаа өргөдөл, гомдолтой харьцуулахад өндөр байгаа.

Төрийн байгууллагууд үндсэндээ иргэд, иргэдээс өргөдөл, гомдол авч байгаа сувгуудыг харьцангуй нэмж ажиллаж байгаа. Ялангуяа цахимаар авах боломжууд нэмэгдсэн. Гэвч энэ 3 жилийн дунджаас харахад биечлэн очиж өргөдөл, гомдол өгдөг байдал 44.5 хувиас дээш хувьтай явж байна.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар дээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг аваад үзэх юм бол нийт

- 2023 онд 266 мянга 075,
- 2024 онд 194 мянга 543,
- 2025 оны гуравдугаар улирлын байдлаар 129 мянга 349 гомдол ирсэн.

Үүнээс аваад үзэх юм бол нийт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргаж байгаа өргөдөл, гомдлын 38-аас 40 хувийг нь зөвхөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргасан өргөдөл, гомдол эзэлж байгаа.

Энэ өргөдөл, гомдлуудын шийдвэрлэж хариу өгсөн байдлыг нь бид хүснэгтээр тэнд харуулсан байж байна.

2025 оны гуравдугаар улирлын байдлаар 119 мянга 223 гомдол шийдвэрлэж хариу өгсөн.

- Бусад байгууллагад шилжүүлсэн нь 1507,
- хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн нь 610,
- хугацаа нь болоогүй байгаа буюу тайлант хугацаанд шийдвэрлэлтийн шатад байсан 6961 нь шийдвэрлэх боломжгүй буюу орон сууц хүсэх, санхүүжилт хүсэх гомдлууд дийлэнхийг нь эзэлдэг юм билээ.

Бидний дүн шинжилгээ хийснээр авч үзэхэд.

Дараагийн слайд дээр би төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг харуулж байна.

Гуравдугаар улирлын байдлаар 101 мянга 559 гомдол төрийн захиргааны төв байгууллагуудад ирүүлсэн байна.

Маш олон харьяа агентлагуудтай байдаг гэдэг юм уу, эсвэл салбарын хамрах хүрээний байдлаасаа болоод Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Барилгын яаман дээр гомдол гаргаж байгаа иргэдийн тоо харьцангуй өндөр байгаа.

Мөн шийдвэрлэсэн байдлыг харуулж байна.

- Нийт өргөдөл, гомдлын 95 мянга 216 нь хугацаа өгч шийдвэрлэсэн.

- Бусад байгууллагууд хоорондоо шилжүүлсэн 4563,
- хугацаа хэтрүүлсэн нь 1086,
- хугацаа болоогүй байгаа шийдвэрлэлтийн шатад явж байгаа нь 4577,
- шийдвэрлэх боломжгүй гэсэн нь 185 гэсэн үзүүлэлт харагдаж байна.

Өмнөх онуудынхыг мөн слайд дээр үзүүлсэн.

Тэгээд 3 жилийн дунджаар аваад үзэхэд бид өргөдөл, гомдлыг яах гэж бүртгэж аваад, яагаад чи хагас жилээр үнэлэлт, дүгнэлт өгөөд байгаа юм бэ гэхээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдсанаас хойших хугацаанд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагаанд аль хэсэгт нь иргэд илүү гомдоод байгаа юм бэ.

Энэ гомдоод байгаа асуудал нь –

- хуульдаа байдаг юм уу,
 - тогтолцоондоо байгаа юм уу,
 - хүнээс шалтгаалсан асуудлууд байна уу –
-

-гэдэг дээр дүн шинжилгээ хийх гэж оролдсон.

Байгууллага харьцангуй шинэ учраас бид хүртэл энэ ажлаа харьцангуй сайн хийж чадаагүй. Алхам алхмаар ажлаа ахиулж байна.

Тэгэхээр одоо миний тайлагнаж байгаа хугацааны 3 жилийн байдлаар төрийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудад ирсэн гомдлуудын ангилалд гурван удаа давтагдсан үзүүлэлтээр хамгийн өндөр байгаа нь энэ ногооноор тэмдэглэгдсэн байж байна.

- ▶ е-баримттай холбоотой,
- ▶ хууль, эрх зүйн асуудалтай холбоотой,
- ▶ эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай холбоотой,
- ▶ санхүү, гааль, татвартай холбоотой,
- ▶ боловсролын салбарын үйл ажиллагаатай холбоотой,
- ▶ хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар, нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой –

-гэдэг нь 3 жил давтагдан өндөр үзүүлэлттэй өргөдөл, гомдол авсан гэсэн үг.

Дараагийн асуудлуудыг нь цэнхрээр тэмдэглэсэн нь 3 жилийн хугацаанд 2 жил давтагдаж орж ирсэн асуудлууд байна.

Тэгэхээр 2 жил давтагдаж орж ирсэн асуудлууд дээр төрийн захиргааны төв байгууллага, агентлагууд дээр –

- архив бүртгэлийн асуудал,
- зам, замын салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудал,
- төрийн албан хаагчийн ёс зүйн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд,

-яам, агентлагууд дээр түлхүү орж ирсэн.

Орон нутаг дээр илүү аж ахуйн чиглэлтэй орон сууц нийтийн ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой –

- дэд бүтэц,
 - авто зам,
 - гудамж талбайн тохижилт,
 - эрүүл мэнд,
 - газрын харилцаа,
 - боловсрол,
 - барилга,
-

— хууль шүүхийн –

-асуудлууд орж ирсэн.

2 жилийн давтамжтайгаар орж ирсэн асуудал нь орон нутаг дээр нийтийн тээврийн асуудал орж ирж байгаа.

Сүүлийн өнгөөр тэмдэглэгдээгүй асуудлууд нь нэг жил давтагдсан нэг жил үзүүлэлтүүд нь гарч ирсэн асуудлууд байна.

Тэгээд би тайлангийнхаа эхэнд дурдсан. Ер нь иргэд бидний тайлагнаад байгаа шиг 80-аас 90 хувьтай шийдвэрлэлтэд сэтгэл хангалуун байна уу гэдгийг түүврээр авч үзсэн.

Тэр болгон бидний хувьд, хүн хүчний хувьд ч тэр боломжийн хувьд ч тэр өнөөдрийг хүртэлх хугацаанд бүх иргэдтэй буцаж холбогдоод сэтгэл ханамжийг нь судлах боломж хязгаарлагдмал байлаа.

Бид энэ хугацаандаа 1300 орчим иргэнтэй түүврийн аргаар судалж үзсэн. Тэгэхэд сэтгэл ханамжгүй байдал 40-өөс 84... /минут дуусав/

Х.Баасанжаргал: 5 минутаар индрийн микрофоныг сунгаад өгөөч. Тэгээд 5 минутдаа багтаагаад явъя.

Б.Батцэцэг: Сэтгэл ханамжгүй байдал Та бүхэнд үзүүлж байгаачлан салбараасаа хамаараад 40-өөс 84 хувьтай сэтгэл ханамжгүй байдал буюу төрийн байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж муу гарсан.

Үүнийг бид Засгийн газрын түвшинд танилцуулаад ярьсан.

Бид иргэдийн өргөдөл, гомдол дээр ямар ажил хийгээд байгаа юм бэ гэхээр манай үндсэн чиг үүрэг –

- тандан судлах,
- процессыг нь дахин инженерчлэл хийх,
- иргэдийн өргөдөл, гомдлоор хяналт шалгалт хийх.

Бусад хяналт шалгалтынхаа хүрээнд төрийн албан хаагчдынх нь тухайн байгууллагаар үйлчлүүлэгдэж байгаа иргэдийн сэтгэл ханамжийг байнга хажууд нь дүгнэлт хийж авч явдаг.

Энэ хугацаанд бид –

- хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар,
- эрүүл мэндийн салбар,
- байгаль орчны салбар,
- Гаалийн ерөнхий газар дээр “процессын дахин инженерчлэл”, “чиг үүргийн шинжилгээ” хийсэн.

Хяналт шалгалтын хүрээнд бид 1674 өргөдөл, гомдлыг яг манай газар дээр хүлээж авч хянаж шалгасан байна.

Үүнээс 31 байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий хянан шалгагчийн удирдамжтай хяналт шалгалтын ажил хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан.

Тандан судалгаан дээр бид аль болох тухайн жилд илүү их гарч байгаа өргөдөл, гомдол дээр дараа жил нь удирдамжтай хяналт шалгалт, төлөвлөгөөт хяналт шалгалт оруулж, ажил сайжруулах, туслан зөвлөх арга ажиллагаануудыг нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ ажлуудыг хийсэн.

Мөн Хүний эрхийн комисстой болон процессын дахин инженерчлэлийн үр дүнд байгууллагуудтай хамтарч ажилласан ажлууд байна.

Тэгэхээр би түрүүн ярианыхаа эхэнд дурдсан Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар анх удаа өргөдөл, гомдлыг тайлагнах, тайлан мэдээ хүргүүлэх журам батлагдсан.

Тэгэхээр өмнө нь бид өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхээр ямар асуудал үүсээд байсан бэ гэхээр –

- өргөдөл гэж юу юм,
- гомдол гэж юу юм,
- шилжүүлсэн асуудал нь давхардаад байгаа юм уу,
- эсвэл Хэрэг эрхлэхэд өгсөн гомдлыг иргэн, хувийг гээд олон газар өгдөг.

Эсвэл Хэрэг эрхлэхээс гомдол шилжээд салбарын яамд руу очдог.

Энэ гомдол давхардагдаж бүртгэгдээд байна уу, эсвэл салангид бүртгэгдээд байна уу. Энэ тоон мэдээллийг гаргахад.

Мөн агуулгыг гаргахад маш хүндрэлтэй байсан.

Энэ журмаар бид харьцангуй тайлагнах маягт, агуулгыг илүү тодорхой болгож өгснөөрөө дараа дараагийн өргөдөл, гомдол шийдвэрлэлт, түүнээс гарах шийдвэрийг илүү тодорхой болгох, илүү иргэдийн гомдоод байгаа асуудлыг арилгах боломжийг энэ журмаар бүрдүүлж чадсан.

Энэ журам 2026 оны 01 сарын 01-нээс мөрдөнө.

Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу иргэдээс өргөдөл, гомдол гаргаж байхад давхардаж бүртгэдэг, шийдвэрлэхгүй уддаг, шийдвэрлэсэн гэж байгаа боловч иргэд сэтгэл ханамжгүй байгаа байдал дээр дүгнэлт хийгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын хяналтын газар хоёрт ямар үүрэг өгсөн бэ гэхээр **“Өргөдөл, гомдлын нэгдсэн систем”**-ийг ажиллагаанд оруулна гэсэн.

Энэ систем ажиллагаанд орсноор ямар үр дүн гарах вэ гэхээр хэн гэдэг иргэн хаана, хаана ямар агуулгаар хандсаныг нь бид нэгдсэн системээс шууд хайлтаас харах боломжтой. Тэгэхээр –

- ▷ **Нэгдүгээрт**, өргөдөл, гомдол давхардаж бүртгэгдэхгүй.
- ▷ **Хоёрдугаарт**, аль байгууллага дээр юу хийсэн нь харагдана.

Иргэн буцаагаад e-mongolia аппликэйшнаараа өргөдөл, гомдол нь хаана, хэн дээр явж байна гэдэг нь харагдана.

Тэгэхээр иргэдтэй бид ярихад тэгээд байдаг байхгүй юу. Мэдэхгүй ээ, өргөдлөө өгсөн. Тэгээд алга болсон. Хаана байгаа нь мэдэгдэхгүй гээд.

Тэгээд бичиг хэргээс нь хөөгөөд ярихаар зарим тохиолдолд төрийн албан хаагч нар нь тэр өргөдөл, гомдлоо яаж шийдвэрлэсэнээ мэддэггүй. Мартдаг ч юм уу, эсвэл хэн дээр байгаа нь ойлгомжгүй олон давхардсан шилжүүлгүүд явсан байдаг.

Энэ асуудлуудыг багасгаж бид нэгдсэн системээр мэдээллийг иргэдэд өгөх боломжийг бүрдүүлсэн байгаа.

- Энэ системд **5286** байгууллага бүртгэгдэнэ гэж харж байгаа.

Өнөөдрийн байдлаар бид туршилтын байдлаар ажиллуулаад явж байна.

→ 197 байгууллага бүртгэсэн.

- Нийслэлийн харьяа Улаанбаатар ERP ашиглаж байгаа.
- Able ERP ашиглаж байгаа.
- E-Mongolia-гийн ERP ашиглаж байгаа.

Төрийн байгууллагууд бүртгэгдсэн байгаа.

Туршилтаар ажиллуулаад ирснээс хойших хугацаанд бид **8505** гомдлыг харах боломжтой болсон.

Тэгэхээр өргөдөл гаргагчийнх нь төрлөөр нь бид харах боломжтой.

Манай хууль чинь иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол гэхээр –

- хуулийн этгээд юм уу,
- эсвэл төрийн албан хаагч гомдоод байгаа юм уу,
- эсвэл гадаадад байгаа монгол иргэн гомдоод байгаа юм уу.

Энэ гомдлуудын бүртгэлийн байдалд шинжилгээ хийхэд хязгаарлагдмал байсан асуудлыг бид нэгдсэн системээр шийдэж өгсөн.

Энэ **dashboard real-time** явна. Төрийн байгууллагын эрх авсан албан хаагч хэн нь ч ороод харах боломжтой. “ХУР”-аар дамжуулаад мэдээлэл солилцоод явах боломжийг бид бүрдүүлээд ажиллаж байна.

Ерөнхий сайд дээр ирсэн өргөдөл, гомдлуудын асуудлыг би саяхан давхардсан тоогоор дурдсан.

Хэрэг эрхлэх газраас Ерөнхий сайдад хандаж болон... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Гишүүдээс танилцуулсан мэдээлэлтэй холбоотой асуух асуулт байвал гишүүд саналаа өгнө үү.

Тэгээд үг, асуулт хоёр тусдаа байгаа. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Бат-Эрдэнэ гишүүнээр, О.Саранчулуун гишүүнээр. О.Саранчулуун гишүүнээр тасалбар болгоод асуулт асуух гишүүдийн нэрсийг хаая. /алх цохив/

С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Сонирхолтой судалгаа гарсан байна.

Би энэ өргөдөл, гомдлуудыг харж байхад ихэнх нь хууль эрх зүйн, танин мэдэхүйн шинж чанартай холбоотой асуултууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ юутай холбоотой байна вэ гэхээр бидний зүгээс баталсан хуулиа хэр зэрэг сурталчилж байна вэ гэдэг асуудал маш их дутагдалтай байгаа юм шиг харагддаг.

Тийм учраас Их Хурал ер нь энэ баталсан хуулийг сурталчлах талаар яг ямар сувгаар юу хийж байна вэ?

Надад ирж байгаа өргөдөл, гомдлын дийлэнх нь баталсан хуулийг тодруулах, асуух гэдэг юм уу. Энэ бол бодит өргөдөл, гомдолтой холбоотой асуудал шийдэх зүйлтэйгээ холилдоод ирэхээрээ нэгдүгээрт юу байна.

→ **Хоёрдугаарт**, орон сууцын компани, СӨХ, нийтийн тээвэр гээд л. Үүнтэй холбоотой асуудлууд.

Барилгын яам жишээлбэл хамгийн өндөр байна гээд. Тухайлбал юу байдаг юм бэ? Яамдаас хамгийн өндөр нь Барилгын яам гэх шиг боллоо.

→ **Гуравдугаарт**, гадаадад амьдарч байгаа иргэд гэнэ.

Манай гадаадад амьдарч байгаа иргэд эсвэл мэдэхгүй байна уу, эсвэл холбох, тэд нарын саналыг авах юм нь жоохон боловсронгуй биш байна уу? Тийм ээ? Үүнийг тодруулмаар байна.

- Сэтгэл ханамж 40-өөс 84 гэж байна.

→ 84 хувийн хүртэл сэтгэл ханамжгүй субъект нь аль нь байна?

Ерөнхий сайдад тавьсан асуудлуудаас харахад хамгийн эхэнд “санхүүгийн дэмжлэг”. Ойлгомжтой байх. Хамгийн эхэнд байна.

Дараагийн ороод ирсэн юм нь “томилгоотой холбоотой” гэнэ.

Тэгээд томилгоотой холбоотой гомдол, санал, хүсэлт гэхээр яг ямар субъектүүд байна вэ? Магадгүй томилсон хүмүүс нь, оронд нь халагдсан хүмүүс асуудал тавиад байна уу, эсвэл тэр томилсон газрынх нь албан хаагчид байна уу, эсвэл тэр салбарынх нь хэрэглэгч нар, ард иргэд байна уу гэдэг дээр нарийвчилсан судалгаа, тооцоо байна уу?

▷ **Дөрөвдүгээрт**, өргөдөл, гомдол иргэд ирүүлээд байдаг. Шийдэхгүй удаагаад байдаг. Эсвэл хамгийн их өргөдөл, гомдолд ирээд байдаг хүмүүст ер нь хариуцлагын асуудал гэж яг ямар юм тооцсон бэ?

Энэ чинь өргөдөл, гомдол санал ихээр ихээр ирээд байна гэдэг чинь ажлаа эсвэл муу хийгээд байна уу? Тийм ээ. Муу хийгээд байгаа хүмүүстээ ямар хариуцлага байна вэ?

Бид ч гэсэн Өргөдлийн байнгын хороотой холбоотойгоор би тийм санал өгсөн. Шаардлагатай бол хуульд нь өөрчлөлт оруулдаг юм уу, яадаг юм. Хамгийн

их өргөдөл, гомдол ирээд байгаа, асуудлаа шийдэхгүй удаагаад байгаа газруудад хариуцлагын асуудал ярихгүй бол тэгээд энэ ер нь цаашаа явахгүй юм билээ.

Тийм учраас бидний хувьд үүнтэй холбоотойгоор асуумаар байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг. 6 юу? 6 дугаар микрофоныг.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. 6 асуудал ярилаа.

Батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажил хэр хийгдэж байна вэ гэхээр яах аргагүй 11-11 төв дээр ч ирж байгаа өргөдөл, гомдлын агуулгыг хараад үзэхээр иргэдийн хууль тогтоомж, хууль тогтоомжоор зохицуулж байгаа харилцааны мэдлэг харьцангуй хязгаарлагдмал байгаа.

Уг нь хэмнэлтийн хуулиар чинь хууль тогтоомжийг сурталчлах боломж нь төрийн байгууллагуудад байгаа боловч ялангуяа шинээр батлагдаж байгаа хууль тогтоомж, өдөр тутам амьдралд үйлчилж байгаа журам, стандартуудыг сурталчлах ажил харьцангуй хязгаарлагдмал хийгдэж байгаа юм болов уу гэдэг дүгнэлт манай газраас Засгийн газрын танилцуулга дээр өгсөн байж байгаа.

Гадаадад амьдарч байгаа иргэдийн хувьд бид энэ журмаараа л бүртгэж ангиллыг нь илүү тодорхой болгож гаргаж ирэх гээд байгаа юм. Өмнө нь иргэдээс гээд явдаг. Чухам гадаадад байгаа юм уу, Монголдоо байгаа иргэн өргөдөл гаргаад байгаа юм уу, хүсэлт гаргаад байгаа юм уу гэдэг нь тодорхойгүй яваад байсан. Үүнийг бид энэ журмаар илүү тодорхой болгож, ангиллыг тусад нь нэмж оруулж байгаа.

Ерөнхий сайдын ирж байгаа гомдол дээр илүү томилгоотой холбоотой асуудал анхаарал татаж байна гэдэг нь ихэнх нь ажилд орох хүсэлт байсан. Түүнчлэн Хэрэг эрхлэх газрын дотоодын томилгоотой холбоотой асуудлууд гуравдугаар улирал дээр байсан.

Өргөдөл, гомдолтой холбоотой хариуцлагын асуудлыг байгууллага болгон журамлаж шийдвэрлэж байгаа.

Нийслэл дээр миний слайд дээр гарах гэж байгаад хараахан үзүүлж чадсангүй. Нийслэл дээр хариуцлага процесс маш тодорхой өдөр, хоногоор нь заагаад өгөх өгсөн, журамласан байж байдаг.

Тэгэхээр тэр хугацаандаа өргөдөл, гомдлыг шилжүүлэх, шийдвэрлэх, судлах үйл ажиллагаагаа явуулаагүй бол хариуцлага тооцох журам байгаа. Байгууллага болгон үүнийгээ мөрдөх ёстой.

Барилгын салбартай холбоотой гомдол яагаад их байна гэхээр нийслэл дээр ч гэсэн гарсан. Орон сууц, нийтийн ашиглалттай холбоотой, түүний дагасан дэд бүтэцтэй холбоотой гомдлууд бүртгэгддэг асуудлууд байгаа.

Х.Баасанжаргал: Хариулт болсон уу? Тийм ээ.

Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дүгнэлт зөв л гарсан байна л даа.

Хэд хэдэн асуудал байгаа юм. Яагаад иргэдийн сэтгэл ханамж муу байгаа вэ гэдэгтэй холбоотой. Та хэд ч гэсэн гаргаад тавьсан л байна.

Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой асуудал.

Үүнийг хэдүүлээ ер нь яаж дүгнэх ёстой юм бэ? Ажлын 5 өдөр хамгийн ядуу юм шиг л хувцастай. Хагас сайн, бүтэн сайн өдөр хамгийн үнэтэй машин, хамгийн үнэтэй брэндүүд өмсөөд л ийшээ тийшээ гараад явах юм. Тэгээд тэр нь өөрөө иргэдэд харагдаж байгаа шүү дээ. Тэнэг биш.

▷ **Хоёрдугаарт,** ёс зүйн харилцаатай холбоотой асуудлыг нэг тал руугаа энэ харилцаа, хандлагатай холбоотой асуудал дээр яг тухайлсан байдлаар дүгнэлт гаргаж төрийн албан хаагчидтай харилцах харилцаан дээр яаж ажиллах ёстой юм би сайн мэдэхгүй байна. Тухайлбал, яаман дээр сайдтай хэн ойр вэ гэдэг нь бусад төрийн албан хаагчдадаа, дотооддоо ч тэр, гадна талдаа ч тэр их тийм дээрэнгүй харьцдаг. Энэ харилцаа өнөөдөр амьд оршсоор л байна.

Тэгэхээр энэ харилцаа, хандлага, ёс зүй дээр яг яах вэ гэдгийг хэдүүлээ шийдэхгүй бол болохгүй байна.

▷ **Гуравдугаарт,** төрийн албан хаагчид сайд томилогдоод очихоор тэгдэг юм уу, эсвэл яадаг юм. Би ерөөсөө ойлгохгүй байгаа. Үүнийг. Энэ дээр иргэдийн сэтгэл ханамжгүй байдал нөлөөлөөд байна.

Миний үед 2023 онд хийсэн байсан ажлыг сая дахиад хийлээ гээд л фэйсбүүк дээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам мэдээлж байх юм. Өмнө нь 2022 онд хийсэн байсан ажлыг өмнөх сайдынх нь хувьд мэдээлж байсан. Энэ чинь одоо нэг ажлаа хийгээд болсон, цахимжуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр шийдээд, шилэн болгосон байсан бүх ажлыг л дахиад хийлээ гээд л мэдэгдээд байдаг.

Тэгэхээр эсвэл шинэчилж хийгээд байгаа юм уу? Эсвэл тэрийгээ сайд нь мэдээлэлгүй байгаатай холбож дахиж хийсэн юм шиг сайдыгаа ажил хийсэн болгож харагдуулах гээд зарлаад байгаа юм уу?

Энэ хугацаанд чинь иргэдийн өргөдөл, гомдол байдаг юм уу, тусгай зөвшөөрөл хүсэж байгаа харилцааг удаашруулах процесс явагдаад байх шиг байгаа юм. Үүнийг шийдмээр байна.

Байгаль орчны яаман дээр ингэж байна гэнэ. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр байгаа газрыг зөвлөл нь хуралдаад, сайдын түвшин шийдсэнийг Тамгын газрын дарга нь оруулж ирснээ энэ дээр дотоод аудит хийнэ гээд зогсоочхож байна гэнэ. Үүнийг ойлгохгүй байгаа юм.

Гэх мэтчилэнгээс авхуулаад энэ хүнд суртал гэдэг юм чинь яаман дээр арай дэндүү болсон юм биш үү.

Дахиад нэг асуудал байна. Энэ эргэн мэдээлэх байдал тодорхой бустай холбоотой асуудал. Гомдол хүлээж авлаа гээд эргээд хариу байхгүй. Үүнийг хэдүүлээ яаж шийдвэрлэх вэ? Энэ дээр чинь сэтгэл ханамжийн асуудал нөгөө талдаа хөндөгдөөд байна шүү гэдгийг хэлье. Тэгээд энэ асуултуудад хариулт аваад дахиад тодруулъя.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг.

Б.Батцэцэг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Төрийн албан хаагчдын харилцаа, хандлагын асуудлыг бид тал талаас нь тал бүрээс нь судалж үзэх гэж хичээж байгаа. Яагаад гэхээр хувь хүнээс шалтгаалсан асуудал байна. Тэр зайлшгүй нэг нөхцөл байдал нь болж байгаа.

Нөгөө талаасаа бид шалгалтаар явж байгаа байгууллага болгон дээрээ, процессыг нь дахин инженерчлэл хийж байгаа байгууллага болгон дээрээ төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг авч байгаа.

Тэгэхээр төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа аваад сэтгэл ханамж өссөнөөр бүтээмж 20-оос дээш хувьтай өсдөг гэсэн олон улсын судалгаа байдаг юм билээ.

Тэгэхээр нийтлэг байдлаараа төрийн албан хаагчид энэ судалгаанд юу гэж хамрагдаад байна гэхээр –

- ажлын хиймэл ачаалал маш ихтэй,
 - удирдлагын арга барил хоцрогдсон,
 - субъектив хандлага ихтэй –
-

-гэсэн хариултуудыг өгч яваа.

Энэ нь ажилдаа хандах, иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ зан харилцааны доголдол гарах бас нэг үндэслэл болоод байх шиг байгаа юм.

Нөгөө талаар ёс зүйн асуудлыг хөндөж тавьж байна.

Би яах вэ, илүү үнэлдэг, тайлан дээр нь ажилладаг байгууллагын өнцгөөс ярьж байж магадгүй.

Ёс зүйн асуудлыг Төрийн албаны зөвлөл дээр Ёс зүйн зөвлөл байгуулагдаад байгууллага болгон дээр ёс зүйн хороод ажиллаж байгаа. Засгийн газраас баталсан Ёс зүйн дүрэм байгаа.

Бид юу оруулж ирсэн гэхээр 2025 онд 43 дугаар тогтоол гэж батлагдсан. Засгийн газрын. Түүн дээр “байгууллагыг үнэлэх” гээд.

→ Байгууллагыг үнэлэхдээ “гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г нь “ёс зүйн асуудлыг үнэлэх” шалгуур болгож оруулж ирсэн.

Тэгэхээр төрийн албан хаагчдын харилцаа, хандлагыг хүнээс шалтгаалсан харилцаа, хандлагыг нь засах оролдлого энэ маягаар хийгдээд явж байгаа.

Та Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг сонгож ярилаа.

Тэгэхээр үүнтэй холбогдуулаад хэлэхэд яах аргагүй төрийн байгууллагын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн асар өндөр явж байгаа. Ялангуяа Байгаль орчны яаман дээр.

Таныг сайд байсан үеэс хойш бидний “процессын дахин инженерчлэл” хийх үе нэлээн өндөр, 80-аас дээш хувьтай хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн.

Тэгэхээр төрийн байгууллагын “бодлогын тасралтгүй байдал”, “төрийн албаны залгамж халаа” гэдэг юм алдагдах эрсдэлтэй байна гээд эрсдэл нь өндөр гарсан тайлан байгаа. Бид Засгийн газрын хуралдаанд 2025 оны 6 сарын сүүлээр танилцуулагдсан.

Х.Баасанжаргал: Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Ер нь Та хэд дахин инженерчлэлийн хүрээнд юу гэж бодож байгааг би сайн мэдэхгүй байна. Нэг юм орж байгаа юу, үгүй юу.

Төрийн албан хаагчид ерөнхий шалгалт өгч байна. Тусгай шалгалт өгч байна. Энэ хоёрыгоо өгвөл насан туршдаа тэнд дархлагдаж байна. Ерөөсөө аттестатчилал явахгүй байна. Төрийн албан хаагчдын дунд.

Тэгэхээр ядаж дахин инженерчлэл дотроо төрийн албан хаагчдын аттестатчилалтай холбоотой асуудлыг ядаж 2, 3 жилийг нь больё. Ядаж 4 юм уу, 5 жил байдаг юм уу. Уг нь боломж байдаг бол 2 жил тутам аттестатчилал хийдэг болвол, 3 жил тутам аттестатчилал хийдэг болвол та хэдийн яриад байгаа иргэдийн

- “сэтгэл ханамж”,
- “сэтгэл зүй”,
- “ёс зүй”,
- “хандлага” –

хамаг юман дээр нөлөөлөх гээд байгаа байхгүй юу.

Нэгэнт тусгай шалгалт өгвөл 15 жил байсан ч тэнд явдаг болохоор энэ болохгүй байна. Тэгээд би үүнийг асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг.

Б.Бат-Эрдэнэ: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Энэ яг миний хариуцаж байгаа чиг үүргээс арай хол. Тэгэхдээ би Хэрэг эрхлэх газар дээр Хүний нөөцийн асуудлыг хариуцсан дэд даргаар жил гаруй хугацаанд ажилласан. Төрийн албаны хуулийн шинэчлэл хийх гээд олон судалгаанууд үзэж танилцсан л даа.

Тэгээд ямар асуудал байна гэхээр яах аргагүй орц нээлттэй. Гарахад маш хэцүү. Тэгээд менежерүүдийн түвшинд, удирдлагуудын түвшинд ажил хийхгүй байгаа хүн дээр хариуцлага тооцоод төрийн албанаас гаргах, нөгөө ур чадвартай, мэргэшсэн албан хаагчийг ажиллуулах гэдэг жоохон хүндрэлтэй байгаа юм.

Тэгэхээр хуулийн төсөл, концепц тухайн үед бид 3 жил тутамд “ротацын систем” оруулж ирэх ёстой юм байна. Аттестатчилал хийгдэж ур чадварын хүрээг нь тодорхойлох замаар яг меритээр хөгжих боломжийг нь гаргаж өгье гээд хуулийн төсөл яригдаад явж байсан. Одоо гэсэн ажлын хэсгүүд гаргаад явж байгаа болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр таны хэлж байгаа саналтай би санал нэг байна. Хариулахад жоохон хэцүү байна. Миний өөрийн хувийн бодол л болчихоод байх шиг байна.

Х.Баасанжаргал: Нэмэлт тодруулга. Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Харин тийм.

Тэгэхээр дарга аа, асуудлаа шийдэхийн тулд углуургаа шийдэх ёстой. Тийм ээ.

Тэгэхээр Та бүхнийг санал оруулаад процессыг нь дахин инженерчлэлийн түвшинд хэлсэн шүү.

Та бүхэнд энэ төрийн өмчит компанид хөгжлийн төвүүд хамаарч байна уу, үгүй юу? Энд одоо солиоруулж байна. Тэр төрийн өмчит компаниудын хүмүүсийн хандлага. Барилгын хөгжлийн төв. Жишээлбэл. Энэ чинь ялгаагүй иргэдэд зөвшөөрөл олгоод, иргэдтэй харьцаад байгаа шүү дээ.

Ийм төрийн өмчит компани, “хөгжлийн төв” нэртэй газруудаар дамжсан төрийн албан хаагч нэртэй ч юм шиг, нэргүй ч юм шиг төрийн нэр бариад ажиллаад байгаа албан хаагчдын асуудал дээр хэдүүлээ гарц шийдэл гаргахгүй бол танайх Засгийн газрын хэрэгжүүлэх газар учраас би хэлж байгаа юм шүү гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь, шинээр томилогдож байгаа албан тушаалтнууд. Би тэд хоногийн өмнө томилогдсон, 3 сарын өмнө томилогдсон, 2 сарын өмнө томилогдсон. Би наадахыг чинь мэдэхгүй асуудал байна. Миний өмнөх асуудал учраас надад хамаагүй гэж хаяж байна. Энэ өөрөө яах аргагүй нөлөөлж байна. Энэ дээр ямар бодолтой байна.

Х.Баасанжаргал: Хамаарах чиг үүргийн хүрээнд. Тийм ээ. 6 номерын микрофоныг.

Б.Батцэцэг: Яг энэ өргөдөл, гомдол шийдвэрлэлттэй холбоотойгоор төрийн өмчит компаниудын өргөдөл, гомдлын асуудал ерөөсөө бүртгэгдэж нэгтгэгддэггүй байсан асуудлыг миний түрүүн танилцуулсан 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхлэх журам дээр төрийн өмчит компаниуд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй, мөн түүнд хийсэн дүн шинжилгээнийхээ тайланг ирүүлэхээр тусгагдсан байж байгаа.

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн дагуу бид төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, төрийн өмчит компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх эрх байгаа.

Төрийн албан хаагчдын хувьд яах аргагүй бид ч гэсэн хяналт шалгалтаар юм уу, процессыг нь дахин инженерчлэл хийгээд очиход ажлын байранд бэлтгэгдсэн байдал харьцангуй муу байдаг. Би мэдэхгүй байна, надаас урдах хүний асуудал, эсвэл энэ надад хамаагүй ч гэдэг юм уу энэ хандлага маш элбэг ажиглагдаж байгаа.

Тэгэхээр бид Төрийн албаны зөвлөлтэй юу яриад байгаа вэ гэхээр тусгай шалгалтын агуулга ч гэсэн хувь хүний тухайн ажлын байранд бэлтгэгдсэн байдал руу их хандах ёстой юм болов уу гэдэг асуудал дээр санал солилцоод явж байгаа. Тэгэхгүй бид бэлдсэн тест аваад, тэгээд хэдэн удирдлагын академиас бэлдэж боловсруулсан асуулт аваад тухайн хүнийг ажлын байран дээр бэлэн гэж үзээд байх нь учир дутагдалтай юм шиг байгаа юм.

Х.Баасанжаргал: Би ажлын хэсгийн гишүүдээ танилцуулаагүй асуулт, хариултыг шууд эхлүүлсэн байна. Д.Батбаяр гишүүн түр хүлээж байгаарай.

Ажлын хэсэг. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Мэдээллийн технологи, системийн шинжилгээний газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Н.Баярмаа, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгаа, бодлого, төлөвлөлтийн газрын Төлөвлөлт, дахин инженерчлэлийн хэлтсийн референт Н.Лхам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч И.Давааноров, Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн Шийдвэрлэлт хариуцсан менежер М.Үүрийнтуяа гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг.

Д.Батбаяр гишүүний микрофоныг.

Д.Батбаяр: Процессыг нь дахин инженерчлэл. Уг нь аягүй сүртэй, гоё нэр байгаа юм л даа.

Тэгээд жил хагасын өмнө биеэ даасан бараг яамны хэмжээтэй эрх үүрэгтэй байсан. Анх гарч ирж байхад нь Э.Одбаяр сайд өргөн агуулгаар нь гүнзгийлээд, ажил үүргийн томъёоллоод уг нь их гоё санаа гаргаж ирж байсан юм.

Одоо тэгээд яамны доор агентлаг болоод очсон байгаа.

Бид Улсын Их Хурал, Байнгын хороон дээр ажил тайлагнахдаа ч тэр, засаг дээр ч гэсэн ажиглаж байхад –

- нэг бол мэдээллийн компани шиг,
- нэг бол судалгааны компани шиг,

— нэг бол маркетингийн компани шиг л болоод байгаа юм.

- Баахан тоо ярьдаг,
- баахан судалгаа ярьдаг,
- баахан санал тавьдаг л болоод байна л даа.

- Уг нь ийм ийм асуудлууд байна.
- Энэ асуудлууд дээр ингэж ингэж шийдсэн.
- Энэ асуудлууд дээр хууль зүйн хувьд ийм гаргалгаа байна.
- Ийм ийм хуулийн шийдэл байхгүй байна ч гэдэг юм уу.

- Улсын Их Хурал дээр үүнийг шийдэх хэрэгтэй байна.
- Шинэ хууль гаргах хэрэгтэй байна.
- Энэ заалтыг зөрчиж байна.

Ийм давхардал байна гэдэг байдлаар ер нь яригдаж явж байх ёстой байсан байх л даа. Тэгээд харамсалтай байна.

Яах вэ, энэ презентэйшнийг аягүй гоё тавиад байгаа. Одоо бид чинь. Презентэйшнийгээ аягүй гоё тавьж ирээд дахиад энэ дээр нь баахан тоонууд тавиад. Нөгөө тоонууд нь хоёр хонохгүй мартагдаад дуусдаг л болоод байгаа юм л даа.

Тэгээд сая Б.Батцэцэг дарга мэдээж тодорхой хэмжээгээр мэдээлэл өгөх нь зөв л дөө. Тэгэхдээ бид энэ “процессын дахин инженерчлэл” гэдэг юм өөрөө агентлаг нь –

- юу хийх ёстой юм,
- ямар асуудлуудыг шийдэх ёстой юм –

-гэдэг бүх юм нь тодорхой болсон байх ёстой байх. Өдийд нэг жил 3 сар гэдэг чинь их хугацаа шүү дээ.

Тэгээд жишээ нь яг жил болчхов уу даа. Уг нь яг тодорхой жишээн дээр ярих ёстой байсан. Тэгээд түүний нэг жишээ юу байх юм гэхээр Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалтай холбоотой нэг асуудал үүсэж байсан шүү дээ.

Иргэдийн гомдлын дагуу шалгалт хийсэн гэсэн.

- Ямар дүгнэлт гарсан бэ?
 - Ямар үйл явц явсан бэ?
 - Ямар шийдэл байгаа вэ?
 - Одоо хаана явж байгаа вэ? –
-

-гэдэг асуултад Та дэлгэрэнгүй байдлаар хариулвал зүгээр байна. Танд чинь 5 минутын хугацаа байгаа байх. Тийм ээ.

Тэгэхээр дахиад тодруулж асууя. Үүний дараа.

Х.Баасанжаргал: 6 номерын микрофон.

Б.Батцэцэг: Д.Батбаяр гишүүний асуултад хариулъя.

Хоёр асуудал дурдлаа. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй холбоотой би саяхан слайд дээрх санал, дүгнэлтээ танилцуулж амжсангүй. Цагийн хуваарилалтаа буруу хийлээ.

Бид 2 жилийн хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй холбоотой асуудал дээр дүн шинжилгээ хийгээд үзэхээр өнөөдрийг хүртэлх хугацаанд бид хугацаандаа хариу өгч байна уу гэдэг дээр маш хүчтэй анхаарал тавьж, иргэдийн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийд гээд байсан.

Манай байгууллага байгуулагдсанаар би бас одоо энэ ажлыг аваад 5 сар болох гэж байна.

Манай байгууллага байгуулагдсанаар ямар үр дүн гарсан юм бэ гэхээр энэ өргөдөл, гомдолд дурдсан асуудал өөрөө шийдэгдэж байна уу, үгүй юу гэдэг дээр дүн шинжилгээ хийх хууль зүйн боломж нь бүрдсэн.

Энэ ажлаа бид хийгээд явж байгаа. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуулийн хувьд үйлчлэл 95 оноос хойш явсан хууль гэдэг чинь одоо учир дутагдалтай.

Бид хяналт шалгалт хийгээд явж байх хугацаанд хамгийн наад захын жишээ гэхэд иргэд –

- би “шүгэл үлээх” эрхээ хэрэгжүүлмээр байна.
- Би “нэрээ нууцалмаар” байна.

Гааль дээр саяхан. Би танай байгууллагаас гараад гаалийн байцаагчтай тулна.

Тэгэхээр мэдээлэл өгсөн эх сурвалжаа “би нэрээ нууцалмаар байна” гэхэд хуулиараа бид –

- нэр нь тодорхой,
 - утас нь тодорхой,
 - хаяг нь тодорхой гомдол хүлээж авах болоод байгаа байхгүй юу.
-

Тэгэхээр концепцын хувьд энэ хууль дээр бас өөрчлөлт оруулах ёстой.

Нөгөөтээгүүр иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гэхээр хуулийн этгээдүүд маань яах билээ, төрийн бус байгууллагууд яах билээ гээд бас ингээд энэ асуудлууд бид нарт байгаа. Үүнийг шийдвэрлэх ёстой асуудлуудын нэг болов уу гэж харж байгаа.

Дарханы Засаг дарга Б.Азжаргалтай холбоотой. Энэ чинь 2025 оны эхээр билүү дээ хийгдсэн хяналт шалгалт байсан. Иргэний гомдлын дагуу. Тийм. Иргэний гомдлын дагуу хийсэн хяналт шалгалт байсан.

Худалдан авах ажиллагаатай холбоотой нэлээн олон зөрчил илэрсэн талаар мэдээлэл гарсан байсан. Манай байгууллага хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглаад.

Асуудал юундаа байна вэ гэхээр бас нэг ийм асуудал байна. Төрийн байгууллагын томилгоо тогтвортой биш байдгийн нэг гай нь гарч ирж байгаа юм.

Манай байгууллага дээр томилгооны асуудал. Нэлээн өндөр тооны хууль бус томилгооны асуудал байсан. Цэгцэлсэн. Архив байхгүй. Архив байхгүй асуудал байгаа.

Засаг дарга Б.Азжаргалтай холбоотой асуудал дээр манай байгууллагад хяналт шалгалт хийсэн архив байхгүй. Албан хаагчид нь хүлээлгэж өгөөгүй яваад өгсөн. Одоо би өнөөдрийг хүртэл тэр шалгалтын тайлангийн араас хөөцөлдөж байгаа.

Тэгэхээр Дарханы иргэдийн Төлөөлөгчдийн Хурал руу явуулсан тайлан манайд байгаа гээд байгаа тайлан зөрүүтэй. Манайд байгаа тайлан дээр албан хаагчдын гарын үсэг дутуу.

Тэгэхээр тэр үнэн тайлан юм уу, худлаа тайлан юм уу би хэлж чадахгүй байгаа.

Х.Баасанжаргал: Д.Батбаяр гишүүн тодруулж асуух уу? Д.Батбаяр гишүүний микрофоныг.

Д.Батбаяр: Энэ чинь ёстой аягүй ноцтой юм болсон байна шүү дээ. Нөгөө бүтэн жилийн хугацаанд ажилласан хяналт хэрэгжүүлэх газрын тайлангууд алга болсон.

Үргэлжлүүлээд ажил хийгээд явж байгаа улсуудад цааш нь ажиллах ямар ч боломжгүй болсон байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ахиад тодруулдаг юм уу, тэгээд ажлын хэсэг гаргадаг юм уу. Ингэж явахгүй үнэхээр болохгүй болсон байна.

Тэгэхээр надад ирсэн мэдээллээр энэ тайлан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр очсон. Авлигатай тэмцэх газар дээр очсон байх учиртай шүү дээ.

Тэгэхээр энэ дээр чинь бид өөрсдөө өөрсдийнхөө журмаар тодруулга лавлагаа авахгүй бол болохоо байсан байна шүү дээ. Та нарын хийсэн ажил чинь алга болсон байна гэсэн үг байна. Тийм үү?

Тэгвэл дахиад нэг асуулт асууя даа. Би дахиад нэг асуулт асуух боломжтой. Тийм ээ. Та 1 минут нэмээд сунгаад өггүй юу.

Х.Баасанжаргал: 1 минут нэмж өгье. Д.Батбаяр гишүүндээ.

Д.Батбаяр: Баярлалаа.

Тэгэхээр өнгөрсөн намар их шуугисан. Иргэдээс сошиал орчинд ч гэсэн маш их санал гаргаж байсан. Тэр юу вэ гэхээр Дархан, Сэлэнгийн нутгуудаар хууль бус ашигт малтмал олборлож байгаа асуудлууд байна. Энд нөхөн сэргээлт гэдэг байдлаар маш их хэмжээний хууль бусаар алт олборлож байна гэдэг гомдлууд гарч байсан.

Тэгэхээр энэ талаар танай байгууллага дээр ямар нэгэн өргөдөл, гомдол ирсэн үү? Энэ талаар ямар нэгэн байдлаар Та нар шалгалт явуулсан уу? Шийдвэрлэсэн зүйл байгаа юу гэдэг асуулт байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Тийм. Түрүүн Б.Бат-Эрдэнэ гишүүн бас яриад байсан.

Төрийн албан хаагчдын түр орлон томилох, хууль бус томилгоо ийм хортой байгаа байхгүй юу. Төрийн байгууллагадаа.

Тэгэхээр ийшээ тийшээ явуулсан тайлангууд зөрөхөөр би хаана аль нь яг албан ёсны тайлан юм бэ гэдгийг мэдэхээ больчихоод байгаа байхгүй юу. Бид нарт үлдээсэн тайлан гээд байгаа нь албан хаагчдынхаа хяналт шалгалт хийсэн, манай дээр ахлах хянан шалгагч, түүний доор ажиллаж байсан хэлтсийн дарга хоёр хууль бус томилгоотой хоёр хүн байсан. Төрийн албаны тусгай шаардлага огт хангахгүй хүмүүс байсан.

Тэгэхээр тайлан зөрөөд байгаа юм. Хууль зүйн утгаараа би Монгол Улсын хуулийг хэрэгжүүлж байгаа хэсэгт хяналт тавьж байгаа хүн. Энэ тайланг энэ байж

магадгүй юм, эсвэл энэ нь зөв юм байна гэдэг юм надад архивын баримт байхгүй учраас би ажлаа өгөөд явсан гэх албан хаагчтай холбогдож тайланг нь авах, үнэн зөв байдлыг нь бататгах ажлуудыг хийгээд явж байгаа.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг нэмж 1 минут.

Б.Батцэцэг: Дархан, Сэлэнгийн газар дээр ашигт малтмал хууль бусаар олборлож байгаатай холбоотой асуудлаар манай дээр гомдол ирээгүй.

Тэгэхээр манайхаас шалгалт хийсэн юм байхгүй.

Х.Баасанжаргал: О.Саранчулуун гишүүн асуулт.

О.Саранчулуун: Маш чухал ажлыг хийж байгаа юм байна.

Тэгээд өргөн хүрээнд энэ дээр ажиллаж байгаа багт баярлалаа. Энэ бол хүн болгоны хувьд анхаарал татмаар асуудлууд байгаа.

Надад тодруулах хэдэн асуулт байна. Улсын Их Хурлын гишүүний санал хүсэлт ер нь хаана бүртгэгддэг юм. Би жишээлбэл 100-аад хөгжлийн бэрхшээлтэй ээжүүдийн саналыг нийлүүлээд өөрийнхөө зүгээс судалж үзэнгүүтээ Ерөнхий сайд руу санал явуулж байгаа байхгүй юу.

Гадуур амьдардаг хүмүүс орон гэргүй байна ч гэдэг юм уу. Үүнийг Ерөнхий сайд руу, эсвэл бусад сайдууд руу явуулж байгаа. Улсын Их Хурлын гишүүний зүгээс “албан бичиг” гэдэг хувилбартай санал төсөл маягаар явж байгаа. Энэ судалгаа энэ дээр байгаа юу? Хариулт нь яаж явдаг юм гэдгийг тодруулмаар байгаа.

▷ **Хоёрдугаарт нь,** өргөдөл, гомдол шийдвэрлэлт аягүй өндөр гараад байна л даа. Жишээлбэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 85 хувь шийдвэрлэгдсэн гэж байгаа.

Тэгэхээр энэ шийдвэрлэгдсэн нь яг юу шийддэг юм бол оо? Жишээлбэл, орон сууцын асуудлаар миний санахын бараг 1000 гаруй хүмүүс орон гэргүй байна гэж хандсан байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс. Тэгээд шийдсэн гэдэг чинь.

Хэрэв энэ жишгээр баримжаалал бүгдийг нь орон байртай болгосон гэсэн үг үү? Үүнийгээ шийдсэн гэж хэлээд байна уу? Эсвэл тэр иргэдийн ирсэн бичгийг Барилга, хот байгуулалтын яам юм уу, эсвэл НОСК руу шилжүүлсэнийгээ шийдсэн гэж хайгаад байна уу? Тэр “шийдсэн” гэдэг ойлголт чинь яг юуг хэлээд байгааг тодруулах хэрэгтэй байгаа.

- ▷ **Гуравдугаарт нь,** иргэдийн санал, гомдлыг байгууллагад өгч байгаагаар нь ангилсан байгааг би харж байна.

Тэгэхдээ өргөдөл, гомдол өгөгчийн нийгэм, хүн ам зүйн талаас нь мэдээлэл байна уу?

- Хэдэн настай, ямар хүмүүс өргөдөл өгөөд байна? Тийм ээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс илүү өгөөд байна уу?
- Ахмадууд өгөөд байна уу?
- Орон нутгаар нь тэр өгөөд байна уу, энэ өгөөд байна уу –

-гэдгээр ангилж гаргавал бид нарт дараагийн тоо баримт дээр тулгуурлаад шийдэл гаргахад арай учиртай болох гээд байна л даа.

- ▷ **Дөрөвдүгээрт нь,** төрийн байгууллагуудын хэд нь хэдэн төрлийн өргөдөл, гомдол хүлээж авах сувагтай вэ? Хэд нь веб сайт нь илүү интерактив загвартай юм бэ гэдгийг тодруулмаар байгаа юм.

Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд өргөдөл, гомдлоо гарга гэхээр юу хэрэгтэй болдог гэхээр жишээлбэл шуудангаар бичгээ өгөхийн тулд тэр хүмүүст мөнгө хэрэгтэй болдог, интернэт хэрэгтэй болно, утасны нэгж хэрэгтэй болно. Аль нь ч болохгүй болохоор биеэрээ очих хэрэгтэй болно. Биеэрээ очих гэхээр унаа машин хэрэгтэй болно. Эсвэл тэргэнцэр, таяг хэрэгтэй болж байгаа юм.

Тэгэхээр энэ төрлүүд дээр төрийн байгууллагууд хүртээмжийн асуудал дээр яг хэр байна гэдэг судалгаа энэ тоон дээр би уг нь харахыг хүсэж байна л даа. Энэ их тодорхой байгаад баймаар байдаг.

Гадаадын байгууллагууд судалгаа хийгээд саналуудаа Засгийн газар, төрийн байгууллага руугаа өгдөг. Энэ санал, хүсэлтийн тойм мэдээлэл ер нь хаана нэгтгэгддэг вэ гэсэн асуултууд байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Би Ерөнхий сайдад хандсан Их Хурлын гишүүдийн санал, хүсэлт хаана бүртгэдэг вэ гэдэг талаар өөрт байгаа мэдээллээрээ хариулъя.

Нэмэлтээр Хэрэг эрхлэх газраас мэдээлэл өгч болох байх.

Их Хурлын гишүүдийн санал, хүсэлт нийтлэг байдлаараа хариуцсан яамд руугаа илүү шилжүүлж шийдвэрлэж байгаа байх. Үүнтэй холбоотойгоор юуг шийдвэрлэсэн гэж үзээд байгаа юм бэ гэхээр Иргэдээс төрийн байгууллага,

албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хууль дээр юуг шийдвэрлэсэн гэж үзэх вэ гэхээр “шилжүүлсэн нь шийдвэрлэсэн” болчхож байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль концепцын хувьд өөрчлөгдөх ёстой гээд бидний яриад байгаа санал энэ.

Шилжүүлж шийдвэрлэсэн чинь иргэний гомдоод байгаа, хүсээд байгаа асуудал шийдвэрлэгдээгүй байхад төрийн байгууллага бид үүнийг 30 хоногийн дотор, эсвэл Хэрэг эрхлэхээс Хяналт хэрэгжүүлэх рүү шилжүүлсэн чинь –

- “шийдвэрлэсэн гомдлын тоонд” ороод байгаа байхгүй юу.
- Хуулийн хугацаанд “шийдвэрлэсэн гомдлын тоонд” ороод байгаа.

Өнөөдрийг хүртэл бид 30 хоногийн дотор уу, 5 хоногийн дотор уу “хугацаанд нь шийдсэн” гэдэг асуудал нь маш өндөр акцент өгч, түүн дээр л анхаарал хандуулж ирсэн шийдвэрлэлтийн хувь 80-аас 90 хувьтай.

Гэтэл жишээ нь орон сууц хүссэн Б.Батцэцэгийн гомдол тэнд шийдвэрлэгдээгүй л байгаа. Тэрийг аль нэг газраа “шилжүүлж шийдвэрлэсэн” гээд л тавьсан байгаа. Ийм асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр –

- “шийдвэрлэлт” гэдэг нь,
- “шилжүүлсэн” гэдэг нь,
- Утсаар, амаар тайлбарлаж хэлсэн нь,
- нөгөө “боломжгүй байна” гэж тайлбарласан нь –

-бүгдээрээ л “шийдвэрлэсэн гэдэг ангилал” руу ороод байгаа юм.

Хүн ам зүйн ангиллаар авч үзэж байна вэ гэхээр бас л өнөөдрийг хүртэл авч үзээгүй байсан.

Журам, нэгдсэн систем ажиллагаанд ороод ирэхээр хүн ам зүйн ангиллаар гараад ирэх боломж нь бүрдэх юм. Энэ нэгдсэн систем бол яг төрийн байгууллагууд одоо ашиглаж байгаа систем дээрээ л холболтууд хийгээд хоорондын саадыг нь арилгасан, төсвөөс ямар ч мөнгө гараагүй ийм систем ажиллаад байгаа.

Хүсвэл Их Хурлаас хандалт авах эрх нь үүсээд, тэрийг бас засаг дээр явж байгаа өргөдлүүдийг **reel time**-аар харах боломжтой болов уу гэж харж байгаа.

Иргэдийн хувьд ямар сувгууд байна вэ гэхээр хэлэлцүүлгийн платформуудаар саналаа өгч болж байгаа юм.

- Утас,
- e-mail шуудан,
- фэйсбүүк,
- албан ёсны хаягт нь “дуут шуудан” үлдээж болж байна.

- Мессеж бичиж болж байна.
- Веб-чат,
- Киоск,
- Веб хуудас,
- Аппликэйшн.

Тэгээд “биечлэн” гээд олон боломжууд байгаа.

Бид байгуулагдсанаасаа хойш би ирээд тоолоход төрийн байгууллагуудын тусгай дугаар 40 орчим тусгай дугаарууд ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ маань яг хэрэглэгч талдаа илүү хэрэглээнд хялбар дөхөм байна уу, үгүй юу гэдэг дээр бид дахиад л үнэлгээ, дүгнэлт өгөх ёстой.

Яагаад гэхээр иргэдийн 11-11 дээр гарч байгаа гомдлууд дунд бид харахаар “утсаа авахгүй байна” гэдэг гомдол маш их. Маш их юу байх вэ. Бас нэлээдгүй хувийг нь эзлээд байгаа юм билээ.

Тэгэхээр төрийн байгууллагууд –

- хариу өгөхгүй байна,
- утсаа авахгүй байна,
- хаана явж байгаа нь мэдэгдэхгүй байна гэдэг асуудлууд байгаа.

Энэ тусгай дугааруудын хэд нь яг хариу өгөөд иргэдэд байнга операторын үйлчилгээ үзүүлээд байна вэ гэдэг дээр ч гэсэн дүгнэлт дүгнэлт хийх ёстой. Цаашдаа бид энэ асуудал дээр илүү анхаарал хандуулаад, илүү дараа дараагийн тайлагналт дээрээ шийдлээ танилцуулах болов уу гэж бодож байна.

Х.Баасанжаргал: Тэр өргөдөл гаргагчдын мэдээллийн талаар судалгаа байна уу гээд асуусан. Тэр асуулт.

Б.Батцэцэг: Нийслэл дээр “мэдээллийн систем” ажиллуулсан юм билээ.

Тэр сайн туршлага гээд би ярих гэж байсан. Түүн дээр судалгаа гаргаад ирж болдог. Нийтээрээ төрийн байгууллагууд дээр байна уу гэвэл байхгүй.

Х.Баасанжаргал: Тодруулж асуух уу? О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Төрийн байгууллагууд маш сайн хүртээмжтэй болж байгаа.

- e-barimt,
- e-mongolia гээд. Тийм ээ.

Гэхдээ түүнд хүн санал, хүсэлт, өргөдөл, гомдол өгөх гэхээр хүртээмжийн асуудлууд ярьж байгаа.

Яг энэ хүртээмжтэй төрийн байгууллагын сайтын тоо гэдэг ч юм уу, 24 цаг ажилладаг утасны тоо гэдэг ч юм уу. Тийм ээ.

Энэ сувгуудын мэдээллүүдийг ер нь хаанаас гаргах юм?

Яагаад гэхээр ер нь иргэд гомдох, ямар нэгэн эрсдэлд орох, асуудалд орсон үедээ л энэ “тусгай дугаар” луу залгаж хүсэлтээ өгч байгаа шүү дээ.

Гэтэл “та ажлын цагаар холбогдоно уу”, “амралтын өдөр байна” гээд хариулахаар хэдэн өдрийн дараа нөгөө хүн чинь юунд гомдсон билээ, яасан билээ гэдгээ мартсан байхад нь бараг нэг мессежээр “таны асуудал шийдвэрлэгдлээ” гэдэг ийм хариулт ирдэг байхгүй юу.

Тэгэхээр энэ хүртээмжийн тал дээр хэзээ тодорхой болох юм, хэзээ сайжрах юм?

Одоо ер нь ямар түвшинтэй байгааг нь хэлээд өгвөл их сайн байх юм.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Өнгөрсөн жил шиг санаж байна.

Засгийн газрын шийдвэр гараад төрийн байгууллагуудын вебсайтыг GOV.MN дээр нэгтгэх шийдвэр гарсан.

Анхны концепц нь яаж явж байсан гэхээр GOV.UK гэдэг шиг GOV.UK 5 настай хүүхэд ороод хэрэглэх хэмжээний user-friendly вебсайтыг Их Британийн Засгийн газар хэрэгжүүлсэн гээд.

Бид энэ концепцоор GOV.MN гээд төрийн байгууллагуудын вебсайтыг шат дараалалтай хаагаад, илүү хэрэглэгчид хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажлууд эхлүүлээд, одоо энэ ажил ч гэсэн зогсоогүй явж байгаа.

Е-Mongol-оор холбосон. Иргэнд өөрт нь хэрэгцээтэй багц үйлчилгээг санал болгодог ч юм уу. Тийм ээ. Тэр холболтууд төрийн байгууллага дээр хийгээд явж байгаа.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. 1 минут нэмээд өгье.

Б.Батцэцэг: “Цахим Монгол” гэдэг үндэсний хөтөлбөр байгуулаад бид Монгол Улсын цахимжилт олон улсын түвшинд үнэлэгдсэн.

Одоо бид юуг үнэлэх ёстой вэ гэхээр гишүүн таны ярьж байгаа шиг цахимжилт маань хэр хүртээмжтэй юм бэ, энэ олон систем хэрэглэгч талдаа хэр хүртээмжтэй байна вэ гэдгийг үнэлэх ёстой.

Бид 2025 оны 11 сарын 10-нд билүү дээ, ажлын хэсэг байгуулсан. Төрийн байгууллага дээр хэрэглэж байгаа системийг тоолох, цахимжилтыг оновчлох ажлын хэсэг байгуулсан.

Тэгэхгүй ингээд байгууллага болгон дээр нэг багц үйлчилгээг авах гэж 3 төрлийн “апп” ашигладаг ч юм уу, ийм байдал ажиглагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр “хүртээмж” гэхээсээ илүү хүндрэлтэй асуудлыг үүсгээд байна.

Тэгэхээр бид цахимжилтаа оновчлох архитектурын зураглалыг зайлшгүй гаргаж ирэх хэрэгтэй юм билээ. Тэгээд манай газар дээр манай Б.Билэгдэмбэрэл дарга ахлаад энэ ажил явж байгаа.

Үндсэн тайлан нь бид 12 сарын 20-оос хойш Засгийн газарт танилцуулах болов уу гэж бодож байгаа.

Х.Баасанжаргал: Д.Ганбаа гишүүн асуулт.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Энэ их гоё хэрэгтэй ажлуудыг хийгээд, их гоё тайлагнаж байна л даа.

Харсан чинь Эрүүл мэндийн яаман дээр хамгийн өндөр асуудал, гомдлууд гарсан.

2773 гээд бусдаасаа гоц тойруулж байгаа байдалтай харагдаж байна.

Энэ тэгээд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй илүү юм байна. Энэ саналууд нь.

Би тэгээд бодож байсан. Нийгмийн эрүүл мэндтэй холбоотой гомдлууд нь яг хаашаагаа очдог вэ? Жишээлбэл, манай Х.Нямбаатар дарга чинь Нийслэлийн

эрүүл мэндийн газрыг татан буулгана гээд сошиал медиа дээр нэг тийм юм явж байсан.

Тэгээд би бодож байсан юм. Нийслэлийн эрүүл мэндийн газрын хамгийн их хүнд хэрэгцээтэй хийх ажил нь –

- орчны бохирдол,
- агаарын бохирдол,
- хөрсний бохирдол,
- усны бохирдол,
- дуу чимээний бохирдол.

Тэгээд явган зам дээр скүүтер энэ тэр янз янзын юмтай юмнуудад дайруул гээд байдаг. Одоо би дандаа алхдаг учраас.

Эдгээр асуудлуудыг яг жинхэнэ барьж авдаг баймаар.

Одоо энэ гомдлууд Та нар дээр ирдэг үү, нэгтгэгддэг үү? Хэрвээ тийм бол олон нийтэд ил тавих асуудал нь яаж явдаг юм гэдэг нэг асуудал байна.

Хоёр дахь нь, бас л орчинтой холбоотой юм даа. Одоо энэ бензин олдож байгаа, олдохгүй гээд л яриад байгаа. Бид яагаад заавал тэр 92 гэж Монголоос өөр хаана ч ашигладаггүй бензин хэрэглээд байдаг. Евро-92 нь олддоггүй. 95 бүр тасраад алга болдог. Үүнтэй холбоотой гомдол.

Энэ чинь орчны бохирдолдоо ч муу байгаа, эргээд эрүүл мэндэд ч муу байгаа. Ингээд бүр бүх талыг хамарсан том асуудал байгаа байхгүй юу.

Эдгээр гомдлууд хотод нийслэлд амьдарч байгаа хүмүүс. Энэ гомдлууд нь холбогдох яамд дээр очъё гэхээр яг Эрүүл мэндийн яам биш, байгаль орчин гэхээр бас биш. Яг л нийслэлд. Тэгээд Нийслэлийн эрүүл мэндийн газарт л харьяалал баймаар санагдаад байгаа юм.

Энэ дээр гомдлууд хаана нэгтгэгддэг юм, яаж харах вэ? Энэ асуудлууд Та нар дээр ирдэг үү? Ирсэн тохиолдолд хэр зэрэг хурдан хугацаанд процесс хийдэг юм? Тэрийг дахиж давтахгүйн тулд эцсийн эцэст ямар corrective action plan¹ хийдэг вэ гэсэн асуулт л байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Н.Баярмаа: Д.Ганмаа гишүүний асуултад хариулъя.

¹ **Corrective Action Plan** буюу **CAP** гэдэг нь гарсан алдаа, дутагдал, эсвэл хүлээгдэж байсан үр дүнгээс зөрсөн асуудлыг засах болон дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн алхам алхмаар бичсэн төлөвлөгөө.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх гомдол төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагын хамгийн их давхардаж байгаа гомдлууд.

Гомдлын агуулгаар нь үзэх юм бол –

- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ,
- эмнэлгийн цаг,
- очер дараалал, хүлээлтийн асуудал,
- цахимжилттай холбогдолтой.

Эмнэлэг болгон тус тусдаа программтай.

Дараагийн асуудал.

- Эрүүл мэндийн даатгалын битүүмжлэлийн асуудал.

Битүүмжлэлийн асуудал нь битүүмжлэлтэй үед эмч дээрээ цаг авдаг. Очоод эргээд эргэн буцах гэх мэт энэ олон асуудал дээр гомдол мэдээлэл ирж байгаа.

Тэгээд бид 2023 онд Эрүүл мэндийн яам болон Эм, эмийн хэрэгслийн Эрүүл мэндийн даатгалын газар дээр процессын дахин инженерчлэл хийж, эрүүл мэндийн нэгдсэн бодлогоо яам хийж хэрэгжүүлэх ёстой юм байна. Зөвшөөрлийн асуудал. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийг аккретив тооцооллоор явах ёстой гэсэн санал, зөвлөмжүүдийг өгсөн. Тэгээд энэ хүрээнд ч гэсэн яам бодлогын асуудал, Эрүүл мэндийн даатгалын асуудлууд хийгдээд явж байгаа.

Орчны бохирдлын асуудал дээр байгаль орчин, орчны бохирдлын асуудал дээр өргөдөл, гомдол нийслэл болон орон нутгийн түвшинд бүртгэгдээд явдаг.

Тэгээд манай дээр тусгайлан ирсэн гомдол мэдээлэл байхгүй байна.

Хүний эрхийн комисс дээр яг энэ “орчны бохирдол”, “дуу чимээний бохирдол”-ын асуудлаар ажлын хэсэг гарсан хоёр, гурван удаагийн хэлэлцүүлэг хийсэн.

Манайхаас энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа. Бид яг энэ дуу чимээ, барилга байгууламж, автомашины холбогдолтой хяналтыг нь тавих ёстой юм байна гээд бас энэ чиглэлээр холбогдох контентуудыг бэлтгээд иргэд, олон нийтдээ мэдээлэх ажлыг Хүний эрхийн комисстой хамтарсан ажлын хэсэгтэй ажиллаад явж байгаа.

Тэгээд өргөдөл, гомдлын энэ шийдвэрлэлтийн асуудал дээр салбар, салбарын яам, яаманд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгүүлээд яг энэ чиглэлээрээ авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар эргэж тайландаа тусгагддаг байх асуудлуудыг сая журмаар оруулсан.

Бид 2026 онд ил илүү ямар арга хэмжээ авсан юм, яаж шийдвэрлэсэн юм, өөрсдөө дүн шинжилгээгээ хийж ямар арга хэмжээ авсан бэ гэдгийг илүү тодорхой болгоод мэдээллийн системээрээ real time-аар хараад явах боломж нь 2026 оны дараа жилээс илүү нээлттэй болно.

Х.Баасанжаргал: Д.Ганбаа гишүүн тодруулах уу? Тодруулаад. Д.Ганмаа гишүүний микрофоныг.

Д.Ганмаа: Баярлалаа.

Нэг юм дутуу үлдсэн нь одоо ингээд хамгийн их давтагдаж байгаа гомдол, мэдээлэл байгаа шүү дээ. Нэгтгэгдээд. Тийм ээ. Нэг дата бест ч бай, тусдаа ч бай.

Тэрийг дахиж үүсэхгүйн тулд гомдлыг урьдчилан сэргийлэх гэх үү дээ. Тийм ээ. Preventive. Тэр байдал дээр ямар арга хэмжээ авдаг вэ?

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Д.Ганбаа гишүүний асуултад хариулъя.

Манайхаас хагас, бүтэн жилээр гомдлын тайлан оруулаад байгаагийн нэг давуу тал нь, хуулиар олгосон давуу тал нь төлөвлөгөөт хяналт шалгалт хийх боломжтой болсон. Нэг.

Хоёрт, “процессын дахин инженерчлэл” хийх боломжтой болсон.

Процессын дахин инженерчлэлийн хувьд түрүүн Д.Батбаяр гишүүн ярьж байсан. Үүнийг тал тал маш сайн ач холбогдлыг нь ойлгож хийхгүй бол үеийн үед энэ байгууллага байгуулагдсанаас хойш маш их цаг хугацаа, маш их хүн хүч зарж гурав, дөрвөн газар хийсэн.

- Эрүүл мэндийн салбарт саяхан хийснийг ярилаа.
- Байгаль орчин дээр хийсэн.
- Нийгмийн хамгаалал дээр хийсэн.
- Цагдаа дээр хийлээ.

Тэгэхээр хүлээж авах газар тэр концепцыг ойлгохгүй бол явдаггүй юм байна гэдэгт л бид өөрсдөө сургамж авчхаад суугаад байгаа л даа.

Тэгээд хамгийн сүүлийн “процессын дахин инженерчлэл”-ийг бид тухайн байгууллагатайгаа хамтарч хийж үзсэн байхгүй юу. Цагдаагийн байгууллагатай. Арай үр дүнтэй.

Өөрсдөө оролцоод явсан, юу болохгүй байгаагаа мэдэж байгаа, өөрсдийнхөө илүү алхмыг өөрсдөө тоолсон учраас арай илүү үр дүнтэй болсон.

Яг өмнө нь хийсэн процессын дахин инженерчлэлүүдийн үр дүн гэвэл их хүндрэлтэй. Тэгээд энэ цагдаагийнх бол аль 4 сараас хийж эхэлсэн ажил. Өнгөрсөн жилийн 11 сард яригдаж эхлээд 4 сард эхлээд, өнгөрсөн долоо хоногт бид тайлангаа хүлээлгэж өгсөн. Тийм юм билээ.

Бид тэгээд энэ жилийн эцсийн тайланг засагт оруулсны дараа нөгөө... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Л.Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Б.Батцэцэг дарга, Та өөрөө эрх зүйч мэргэжилтэй хүн юм байна шүү дээ.

Тэгэхээр өмнөх ажиллаж байсан хүн чинь архиваа аваад алга болсон дээр гуйгаад сууж байх ёсгүй шүү дээ. Арай гуйгаад суугаагүй биз дээ. Наадхаа та ажил хэрэг болгохгүй бол наадах чинь төрийн байх ёстой архив. Наадах чинь гэмт хэрэг. Тийм үү?

Тэгэхээр энэ дээрээ яаралтай арга хэмжээ авч буцааж Байнгын хороонд ер нь мэдэгдсэн нь дээр юм биш үү гэдэг бодолтой байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлт нь үнэхээр мундаг. Их олон хувьтай, тоо баримт сайхан тавьсан байна л даа. Энэ чинь тэгээд л цохсоноо тавиад байгаа юм биш үү. Тийм ээ. Одоо жишээ нь Засгийн газарт Ерөнхий сайдад ирсэн гомдлыг харахаар. За яах вэ, эдийн засгийн дэмжлэг хүссэнийг би тооцохгүй. Энэ дээр хариу арга хэмжээ авч бараг л чадахгүй дээ. Тийм ээ.

- Томилгоотой холбоотой,
- санал хүргүүлэх тухай,
- хамтран ажиллах тухай,
- бүр биечлэн уулзах хүсэлт байна шүү дээ.

Эд нарыг яаж шийдвэрлэсэн?

Томилгоотой холбоотой бүр их анхаарал татаж байгаа байхгүй юу. Бид сая орон нутагт ажиллаад ирсэн. Энэ томилгоо, төрийн албаны хүнд суртал, иргэдийг үл тоодог, энэ талаар ерөөсөө хүн болгон гомдол тавьж байгаа юм.

Тэгэхээр энэ шийдвэрлэлт өндөр байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр яг яаж шийдвэрлэсэн юм? Би цохсоныг тооцмооргүй байна.

Бид ч гэсэн өдөр болгон санал хүсэлт, гомдол, өргөдөл ирдэг, цохдог. Гэхдээ араас нь заавал асуудаг байхгүй юу. Наад чинь яасан. Тэр хүнд эргэж мэдээлдэг. Энэ дээр тэгвэл ийм өндөр тоо тавьсан юм чинь тэгж шийдээд, тэгж мэдээлсэн гэдэг юм нь юу байна вэ? Би тэрийг их сонирхож байна.

Ялангуяа “биечлэн уулзах хүсэлт”, “томилгоо”-той холбоотой. Энэ дээр асууя.

Бас нэг асуулт байна. Энэ ингээд өргөдөл, гомдлын тоо буураад байгаа их сонин үзүүлэлт байна шүү дээ. Нэг бол үнэхээр иргэдийнхээ асуудлыг сайхан шийдээд байхаар буурч байгаа юм. Асуудалгүй болж байгаа байхгүй юу. Нөгөөдөх нь хүнд сурталтай, эргэж хариу өгдөггүй, асуудлыг нь шийдвэрлэдэггүй больж байгаа юм. Хаданд хашхираад дээ гээд больж байгаа байхгүй юу. Энэ хоёрын ялгааг гаргаж өгөөч.

Энд их сонин тоо харагдаж байна.

- Архангай аймагт өргөдөл, гомдлын тоо огцом буурсан.
- Өмнөговь аймагт огцом өссөн.

Төв аймаг сүүлийн 3 жилээр. Сая өөрийг чинь танилцуулсан. Тийм ээ.

- Төв аймаг бүр огцом өссөн байхгүй юу.

Энэ яг юун дээр өсчөв? Энэ дээр Та нар анхаарлаа тавьсан уу?

Бас нэг хэлсэн үг чинь их сонирхол татлаа. Төрийн албаны залгамж чанар алдагдсан талаар судалгаа хийж, 2025 оны 7 дугаар сард Засгийн газарт танилцуулсан гэж байна. Тийм ээ. Би зөв тэмдэглэж авсан уу, буруу тэмдэглэж авсан уу? Энэ дээр тайлбар хэлээд өгөөч.

Хэрвээ ийм судалгаа байгаа бол энэ судалгааг чинь авмаар байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн хэн хариулах вэ? 9 дүгээр микрофон.

И.Давааноров: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах шинжээч И.Давааноров байна.

Ерөнхий сайдад хандаж албан тушаалын томилгоотой холбоотой асуудлууд гэхээр Засгийн газрын Хүний нөөцийн газарт Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотойгоор шинээр байгуулагдсан нэгжүүдэд төрийн албаны шалгалт өгсөн, нөөцөд байгаа, бүртгэлд байгааг иргэдээс тухайн шинээр байгуулагдаж байгаа албан тушаалд томилуулах хүсэлт гаргасан ийм хүсэлтүүд.

Энэ нь албан тушаалын томилгоотой асуудлууд болохоор Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж байгаа үед яг энэ хүсэлтүүд их нэмэгддэг.

Мөн төрийн албан хаагч, шинээр томилогдож байгаа албан хаагчид зэрэг дэвийн. Тийм ээ. Улс төрийн албан хаагчаас төрийн жинхэнэ албанд шилжих ч юм уу гээд иймэрхүү асуудлууд өндөр үзүүлэлттэй гардаг.

Хоёрдугаар асуудал нь Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдтэй биечлэн уулзах хүсэлт гаргадаг. Өргөдөл, гомдлууд иргэний өөрийн тавьж байгаа өргөдөл, гомдлын хүсэлт нь, яг тавьсан асуудал нь шийдвэрлэгдэхгүй болохоор энэ асуудал чинь ерөөсөө шийдвэрлэгдэхгүй байна аа, Ерөнхий сайд аа, Тийм ээ. Би тэр яаманд очлоо, тэр сайд нь хүлээж авч уулзахгүй байна гэсэн асуудлуудыг тавьдаг.

Уг асуудал дээр ихэвчлэн Ерөнхий сайдын зөвлөхүүд уулзаад явдаг. Тийм. Засгийн газрын асуудал хариуцсан референтүүд, зөвлөхүүд, тухайн асуудлыг нь хариуцсан Засгийн газрын референтүүд уулзаад, тэгээд асуудлыг нь холбогдох газарт нь төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэхээр шилжүүлж шийдвэрлэж байгаа.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Нэмэлт хариулт.

Б.Батцэцэг: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Тэр 7 дугаар сарын төрийн албаны залгамж халаа гэдэг нь зөвхөн байгаль орчны салбарт хийсэн процессын дахин инженерчлэл дээр тухайн салбарын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн өндөр, үйл ажиллагааны эрсдэл үүссэн байна гэдэг дүгнэлт манай тэр дахин инженерчлэлийн тайлангийн нэг хэсэг болоод Засгийн газар танилцуулагдсан.

Гомдол яагаад буураад байна вэ гэдгийг бид бас судалж үзэх гэж оролдсон.

Би үүнийг бүрэн дүүрэн гэж хэлж чадахгүй. Гэхдээ гомдол буурч байгаа нэг шалтгаан юу байна гэхээр манай байгууллага байгуулагдсанаасаа хойш иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж байгаа гомдол гэдэгт чинь лавлагаа чинь орохгүй шүү дээ. Дотооддоо хүний нөөцийн хүсэлтүүд чинь орохгүй шүү дээ. Дотоодын албан хаагч хоорондын гомдлын асуудал чинь орохгүй шүү дээ гээд. Тэрийг тайлагнадаг асуудлыг нь хамтад нь бүртгээд явдаг асуудлыг багасгасан юм.

Магадгүй энэ нэг үзүүлэлт байх магадлалтай.

Өнөөдрийн байдлаар бид өргөдөл, гомдол буурч байгаа асуудал дээр ийм дүгнэлт өгсөн. Тэгэхдээ үүнийг бид илүү дараагийн журмаараа илүү сайжруулахгүй бол манай одоогийн авч байгаа маягт маань ч гэсэн журамгүй. Өмнөхөөсөө арай сайжруулсан хувилбар. Одоогийн маягт бас харьцуулаад харах юм бол 2026 оны маягт арай дэлгэрэнгүй, арай агуулга, үр дүнг нь тооцож болохуйц маягтыг гаргаж ирсэн байгаа.

Х.Баасанжаргал: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд халаа сэлгээ, хууль бус томилгоо их байна гэсэн үг юм уу?

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн гэдэг чинь яг юугаа хэлж байна. Тэрийг тодруулаад өгөөч?

Тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хэрвээ асуудал байгаа бол та нар Засгийн газарт танилцуулсан байна шүү дээ. Мөрөөр нь хяналтаа хэрэгжүүлэх. Танайх чинь хяналт хэрэгжүүлэх газар шүү дээ.

Яг ямар арга хэмжээ авсныг одоо энд хэрвээ хэлж амжихгүй, мэдэхгүй бол надад бичгээр өгөөч. Тэгэх үү? Тэгье гэж бодож байна.

Тэгээд тэр томилгоотой холбоотой гомдлууд ирдэг гэж байна шүү дээ. Тэгээд яадаг юм. Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх болгонд л би дарга больё гэсэн өргөдлүүд ирээд байдаг гэж ойлгох уу? Энэ арай худлаа даа. Надад тэгж санагдахгүй байна.

Тэгэхдээ хэрвээ яг тийм бол тоо баримттайгаар нь одоо хэлж чадвал хэлээд, хэлэхгүй бол бичгээр авмаар байна.

Ерөнхий сайд хүнтэй уулздаггүй юм байна шүү дээ.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофоныг. 7 юу? 7 дугаар микрофоныг.

Ялангуяа томилгоотой холбоотой маш их гомдол, хүсэлтийн тоо нэмэгдээд байна. Түүний өнгөнийх нь асуудал. Тийм ээ. Ямар төрөл гэдгийг нь. Хэрвээ тоо нь байвал. 7 дугаар микрофон.

Н.Баярмаа: Байгаль орчны яаманд процессын дахин инженерчлэлийг 2024 оны 11 сараас хийж эхлээд, дуусаад 6 сарын 04-нд Засгийн газрын хуралдаанд судалгааны тайлангаа танилцуулсан.

Процессын дахин инженерчлэл гэдгийг төрийн байгууллагад хийхэд хуулиар хүлээсэн чиг үүрэг. Нийтдээ 22 хуулиар 442 чиг үүргийг яам яаж хэрэгжүүлж байна вэ гэдэг асуудал. Энэ талаарх дүгнэлт байгаа.

Дээрээс нь нэмээд эрсдэлийн судалгаа байгаа.

Зөвшөөрөл авч байгаа аж ахуйн нэгж, үйлчилгээ авч байгаа аж ахуйн нэгжийн судалгаа, төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа, процесс, зургууд гээд зөвшөөрөл олгож байгаа процесс нь хэр цахимжсан бэ, иргэд, аж ахуйн нэгжүүдэд дарамттай байна уу. Бодлого стратегийн хөтөлбөр гээд 8 чиглэлээр судалгаа, шинжилгээ хийсэн.

Үүн дээр хамгийн гол асуудал Байгаль орчны яам 2022 онд нүүрстэй ч юм уу холбогдолтой нэмэлт... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Нэмэлт 1 минут. 7 дугаар микрофон. Ажлын хэсгийн.

Н.Баярмаа: 2022 онд нийт албан хаагчдын 41 хувь нь шилжилт хөдөлгөөнд орсон.

2023 онд бас тухайн 2022 онд шилжилт хөдөлгөөнд орсон 49 хувийг нөхөгдсөн байлаа гэхэд 2023 онд дахиад 51 хувийн шилжилт хөдөлгөөнтэй.

Төрийн албан хаагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгаа нь одоо яг энэ дотоод энэ зохион байгуулалтын асуудал дээр 3 албан хаагч тутмын 1 нь сэтгэл ханамжгүй байна гэдэг ийм судалгааны дүгнэлтүүд гарсан.

Тэгээд яг энэ судалгааныхаа хүрээнд бид нэгдсэн тайлангаа танилцуулсан. Тэгээд энэ хүрээндээ ч гэсэн зарим асуудлууд шийдэгдээд явж байгаа. Байгаль орчны яам эргэж байр сав нь төрийн байгууллага ийм байх ёстой юм гэсэн энэ шийдлийн дагуу эргээд явж байна.

Бүтэц, зохион байгуулалт нь ч гэсэн 7 газар, 5 хэлтэстэйгээр гээд бид нарын өгсөн газрууд явж байна. Гэхдээ Байгаль орчны яамны дахин

инженерчлэлийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд өгөхдөө 2026 оноос хийж хэрэгжүүл гэсэн байгаа.

Нийт олгож байгаа 38 зөвшөөрлийг цахимжуулах асуудал ч бас одоо гэсэн Төрийн нарийн бичгийн даргаар нь ахлуулаад... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Нэмэлт тодруулга. Л.Мөнхбаясгалан гишүүний микрофоныг. Сүүлийн тодруулга. Тийм ээ. Гурав дахь тодруулга.

Л.Мөнхбаясгалан: Ерөнхий сайд ерөөсөө иргэдтэй уулздаггүй юм байна. Тийм ээ. Зөвхөн зөвлөхүүдээ л уулзуулдаг юм байна шүү дээ. Тэгж ойлголоо.

Сая Байгаль орчин, уур амьсгалын яаман дээр хийсэн. Та тэр 8 чиглэлээр хийсэн зүйлээ наад албан бичгээр явуулаач. Над руу хүргүүлчих. За юу. Бүх юмыг нь яг юугаар нь авъя гэж бодож байна.

Тэгээд тэр санал, гомдол яагаад огцом өсөөд, огцом буураад байгаа дээр судалгаа хийсэн үү? Орон нутгууд дээр. Жишээ нь, Төв аймаг бүүр огцом өссөн байгаа байхгүй юу. Гэтэл нийтдээ буурч байна шүү дээ.

Өмнөговь дээр бас өсөлт харагдаж байгаа юм.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн хэн хариулах вэ?

Л.Мөнхбаясгалан: Архангайд огцом буурсан. Энэ юутай холбоотой юм бол. Уур амьсгалын өөрчлөлт байна уу, өөр ямар нэгэн асуудал дээр байна уу, их сонирхол татаад байх юм.

Н.Баярмаа: Байгаль орчны яамны олон улсын конвенц болон стратеги гээд бүх 8 чиглэлийн судалгаа шинжилгээний тайлан байгаа.

Бид Засгийн газрын нэгдсэн судалгааны сан sudalгаа.gov.mn-д тавьсан байгаа. Би тэгээд таны албан хаягаар яг энэ бүх процессын зурагтай 3 товхимол тайлан байгаа. Үүнийг цахим хаягаар чинь хүргүүлье.

Х.Баасанжаргал: Орон нутгийн өргөдөл, гомдолтой холбоотой хариулт.

Н.Баярмаа: Орон нутгийн өргөдөл, гомдолтой холбогдолтой бид тухайн жил болон улиралд өсөлттэй аймаг, яамыг сонгож аваад яагаад өсөөд байгаа дээр эргээд тандалт судалгаа хийж байгаа.

Тэгээд яг иргэдээсээ гомдол шийдвэрлэсэн гэсэн иргэдээсээ түүвэрлэж аваад манай яг энэ судлаачид утсаар ярьж таны гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ, шийдсэн бол сэтгэл ханамжтай байна уу, шийдээгүй юу гэдэг дээр байгаа.

Тэгээд энэ дүн харин харамсалтай нь шийдвэрлэлт 90 хувьтай гэж байхад энэ дүн 3 яаман дээр гэхэд 3 яам нь сэтгэл ханамжгүй.

Х.Баасанжаргал: Оноо андуурсан уу, үгүй юу гээд байх шиг байна. Тийм.

Саяын Байгаль орчны яаман дээр 2022 он, 2023 оны тэр хүний нөөцийн хувь чинь яг зөв үү. 2023 оны тоо чинь зөв үү л гэж асуугаад байх шиг байна.

Хэн хариулах вэ? Ажлын хэсгээс хэн найруулах вэ? Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Оноо андуураад хэлсэн байна. Гишүүн ээ. Процессын дахин инженерчлэл хийсэн он нь 2023, 2024 оных. Тийм. Сүүлийн оных. 2024 биз дээ. 2024 оных.

Тийм. 2024 оны 7 сараас хойших хийсэн судалгаа.

Саяхан манайх ажлын хэсгээс хариулахдаа он андуураад хэлсэн байна. Тийм. Би бүр яг нарийвчилсан юмыг нь тайлангаасаа одоо харж байгаад хэрвээ боломж олдвол тодруулга хийе.

Х.Баасанжаргал: Би хоёр, гурван зүйл тодруулаад асууя.

Нэгдүгээрт, хариуцлагын тухайд. Түрүүн С.Эрдэнэбат гишүүн анх яг энэ хариуцлагын тухай асуусан. Зарим нэг гишүүд хариуцлагын асуудлыг хөндлөө. Гэхдээ яг оновчтой хариулт төдийлөн сонсогдсонгүй. Хариуцлагын тухай та хэд иргэдийн сэтгэл ханамж наян хэдэн хувьтай байгаа салбарууд. Тийм ээ. 10 хүн тутмын бараг 8 нь өргөдлөө шийдвэрлэж чадаагүй сэтгэл дундуур байгаа салбарууд дээр байгаа хариуцлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг дээр нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт, Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар ер нь иргэдээс өргөдөл, гомдол хэр их ирдэг юм бэ? Ялангуяа хуулийн төсөлтэй холбоотой янз бүрийн саналууд, энэ асуудлыг ингэж хуульчилмаар байна ч гэдэг юм уу. Тийм ээ. Ийм зүйл ирвэл та хэд буцаагаад Их Хурлын Тамгын газар луу ирүүлдэг үү. Ер нь энэ өргөдлүүд ер нь хаагуур байдаг вэ гэдэг хоёр дахь асуулт байна.

Гуравдугаарт, иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай тухай 1995 оны хууль байгаа. Энэ дээр ер нь танай байгууллага одоо хийгдэж байгаа судалгаа, шинжилгээтэйгээ уялдуулаад энэ хуулийн төслийг ер нь хэзээ өргөн барих вэ? Төлөвлөгөө байгаа юу? Хууль ер нь шинэчилж байгаа юу? Энэ дээр та хэд мэдэж байгаа юу? Эсвэл Хууль зүйн яам уу гэдэг нэг асуулт байна.

Тэгээд хамгийн сүүлд танай байгууллага Эдийн засаг, хөгжлийн яаман дээр очсон байгаа. Яамны харьяанд очихоор чинь би жаахан гайхаад л байна.

Тэгэхээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд яамны харьяанд байхаар чинь яадаг юм бол оо? Ийм 4 асуулт байна.

Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя.

Хариуцлагын асуудал дээр явсаар байгаад л тулж очвол төрийн албаны хуульд заасан сахилгын арга хэмжээ авна л гэдэг юман дээр тулж очиж байгаа юм л даа.

Тэгэхээр би байгууллагууд журмаараа зохицуулж байгаа гээд байгаа нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор ямар үйлдэл нь захиргааны хариуцлага болох вэ гэдэг асуудлыг журмаараа зохицуулсан юм байгаа гээд байгаа.

Манай байгууллага байгуулагдсанаасаа хойших хугацааг ярьж байгаа юм. Бидний Засгийн газарт танилцуулсан танилцуулгаас улбаалан хариуцлага тооцсон юм байхгүй. Өргөдөл, гомдлыг эрчимжүүл, асуудлыг шийдвэрлэ, үр дүнг нь буцаж танилцуул гэдэг тэмдэглэлүүд гараад явж байгаа.

2026 онд хэрэгжиж эхлэх гэж байгаа журам үүнийг би ганцаараа хийгээгүй. Бүтэн жилийн турш үе үеийн дарга нар боловсруулалтыг нь хийж явж сайжруулсаар явж байгаад саяхан батлагдаж байгаа журам.

Үүгээрээ бид олон асуудлыг шийдэж чадах болов уу, үр дүнгээ илүү үнэлж чаддаг болох болов уу гэж харж байгаа.

Өргөдөл, гомдлын тухай хуулийн хувьд харьяалах эрхлэх асуудлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдаж байгаа.

Миний хэн мэдэхээр намайг Хэрэг эрхлэх газар ажиллаж байх хугацаанд тухайн үеийн Хууль зүйн сайд О.Алтангэрэл сайд өргөн барих гээд бэлтгэл ажил хангагдаж байгаа гэсэн. Түүнээс хойших мэдээлэл надад байхгүй байна.

Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар, ялангуяа хууль тогтоомжтой холбоотой асуудлаар салбарын яамдад гомдол ирж байгаа бол магадгүй дийлэнх нь судалгаанд тусгалаа гэдэг ч юм уу, шинэ хууль тогтоомж боловсруулахдаа судалгаанд авлаа гэдэг байдлаар шийдвэрлэж байгаа байх.

Нийтлэг байдлаар Хууль зүйн яам руу шилжүүлдэг. Хэрэг эрхлэх газраас. Харьяаллын хувьд манайх өргөдөл, гомдол дээр дүн шинжилгээ хийгээд байгаа нь ганцхан манай хуулиар хэрэгжүүлсэн 5 чиг үүргийн нэг хэсэг нь л юм байгаа юм.

Тэгэхээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримт дээр үнэлгээ хийдэг гэхээр магадгүй Эдийн засгийн яамтай биш бид сайдын харьяаны байгууллага, төрийн байгууллага гэж явж байгаа.

Тэгэхээр яамны харьяанд байхгүй. Үйл ажиллагаагаараа яам манай хяналтын объект болж явдаг.

Тэгэхээр магадгүй хөгжлийн бодлого, төлөвлөлт хийхэд үнэлгээ, мониторинг нь тэр утгаараа яамны үйл ажиллагаатай уялдаж явж байгаа болов уу гэж харж байна.

Намайг ажил авсан үеэс хойш. Би мэдэхээ л ярья. Түүнээс хойш Эдийн засгийн яаманд шилжсэн юм чинь. Түүнээс хойш үйл ажиллагаан дээр хүндрэл учраад байгаа юм харьцангуй алга байна. Бид саяхан 5 жилийн үндсэн чиглэлийн тайланг боловсруулаад, түүн дээр үндэслэсэн шинэ 5 жилийн үндсэн чиглэл боловсруулагдсан гээд явж байгаа.

Бусад нь Засгийн газар дахь хяналтын хуультай учраас тэгээд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээд л явж байгаа.

Х.Баасанжаргал: Хоёрхон зүйл тодруулъя.

Иргэдээс ирж байгаа нийтлэг 3 жил дараалаад давтагдаж байгаагийн нэгдүгээрт е-баримттай холбоотой өргөдөл, гомдол гээд. Энэ юу байгаад байдаг юм? Яагаад шийдвэрлэгддэггүй юм?

Хоёрт, Хууль зүй, дотоод хэргийн яамтай холбоотой ирж байгаа өргөдөл, гомдол бараг нийт өргөдөл, гомдлын гуравны нэг нь байгаа байхгүй юу. Бараг хамгийн их нь байна. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн, Хууль зүй, дотоод хэргийн яам, ялангуяа хууль эрх зүйтэй холбоотой ямар асуудлууд дийлэнхтэй байгаад байдаг юм?

Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Е-баримттай холбоотой гомдлыг. Гишүүн ээ, бид бас шүүж үзсэн. Энэ ямар гомдлууд е-баримттай холбоотой гэж бүртгэгдээд байна гэхээр е-баримт өгөхгүй байна. Е-баримт бүртгэгдэхгүй байна гэсэн гомдлууд. Тэр нь

гомдол гэдэг ангилал дээр байгууллага баталгаажуулахгүй байна ч юм уу, тэр гомдлууд явдаг юм билээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамтай холбоотой яагаад энэ гомдол их байна вэ гээд үнэлгээ өгөх гэж алхам хийсэн.

Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 12 агентлаг байж байгаа.

Тэгэхээр 12 агентлагийн үйл ажиллагаанд холбогдох гомдлууд Хууль зүй, дотоод хэргийн сайдын гомдол дээр нэгтгэгдэж явж байгаа учраас магадгүй их өндөр хувьтай гарсан байж болзошгүй юм билээ.

Цагдаатай холбоотой гомдол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой гомдлууд гээд том том агентлагуудын үйл ажиллагаатай холбогдсон гомдлууд нь бүгд Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр бүртгэгдэж явдаг.

Х.Баасанжаргал: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Уг асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Хэлэлцсэн асуудалтай холбоотой гэсэн үг.

Далайн Батбаяр гишүүнээр тасалбар болгоё. Ж.Золжаргал гишүүний. С.Эрдэнэбат гишүүний микрофоныг.

С.Эрдэнэбат: Ямар ч байсан тайлан танилцуулсанд баярлалаа.

Нэлээн статистик, дататай болж байгаа нь сайн. Гэхдээ дэлгэрэнгүй үзэх шаардлага байна.

“Өргөдөл шийдвэрлэсэн байдал” гэхээр “шилжүүлснийг шийдвэрлэсэн” гээд явахаар наадах чинь өөрөө өөрсдийгөө нэгдүгээрт хуурсан болох вий. Яг иргэдэд юу гэж ойлгогдож байна вэ. Тийм үү. Хамгийн их өргөдөл, гомдол гараад байгаа нь магадгүй хамгийн сайн ажиллаж байж магадгүй шүү. Бид эсрэгээр нь өргөдөл, гомдол их гараад байхаар нь хамгийн муу ч гэдэг юм уу. Тийм ээ. Ийм үзүүлэлт хүн шууд ойлгогдохоор.

Тэгэхээр хамгийн их иргэдийг сонсдог, мэдээллээ их түгээдэг. Үүнээс хүмүүс мэдэх эрхээ хангахаараа хандах эрх нь нэмэгдээд явдаг хандлага байдаг. Тэр утгаар нь би аймгуудыг ч гэсэн харсан чинь заримынх нь огцом өсөөд, зарим нь огцом буураад гээд явж байна.

Тийм учраас энэ тал дээр нь дата анализ хийх нь их чухал байна гэж харж байна.

Хоёрдугаарт нь, e-mongolia-г илүү сайн хялбар иргэдийн өргөдлийг авах, шийдэх гэдэг зүйл рүү нь ажиллуулмаар байна. Тухайлбал, би саяхан эм авах гээд бичүүлээд авах гэж бараг долоо хоног тойрсон. Нөгөөдөх нь дуусчхаад байна л даа. Аптекууд дээр очихоор олдохгүй байсаар байгаа ч гэдэг юм уу. Энэ аягүй их иргэдийг бухимдуулдаг юм байна. Хугацаандаа авч чаддаггүй. Нэг эм авахын тулд Улаанбаатар хотыг тойрдог.

Тэгэхээр эм хаана, хаана байгаа вэ ч гэдэг юм уу. Тийм ээ. Хүнд хамгийн хэрэгцээтэй байгаа мэдээллүүдээ e-mongolia руу нэгтгэхгүй бол бүх төрийн байгууллагуудын аппликэйшнийг суулгаж мэдээлэл авна гэдэг чинь аягүй түвэгтэй.

Тийм учраас мэдээллүүдийг нэгтгэх, мэдээлэл олж авах гэдэг юм чинь өөрөө их чухал байна.

Хуулийн этгээдүүд гэдэг асуудал зөв асуудал байж байгаа. Зөвхөн иргэдээс гэдэг байдлаар орсон учраас магадгүй та бүгд, танай байгууллага, төрийн бус байгууллагууд. Тийм үү. Ийм томоохон хэмжээний төлөөллийн байгууллагуудаас ирж байгаа санал, гомдлыг татаж үзвэл илүү боловсронгуй мэдээ, мэдээлэлдээ анализ хийсэн байдаг шүү.

Тийм учраас ийм талаас нь тэр хууль, дүрэм, журамдаа өөрчлөлт оруулахгүй бол зөвхөн иргэдээс хүлээж авна гэдэг байдлаар байгаад байвал та хэдийн л ажил нэмэгдэнэ. Тэд нар чинь өөрсдөө мэргэшсэн, үнэлэлт дүгнэлт өгсөн байдаг. Үүнийг хэлмээр байна.

Заримыг харахаар манай төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо их муу байна. Би ний нуугүй хэлэхэд хөдөлмөрийн аюулгүй байдлын ажлын хэсэг байгуулаад газ, бензин дэлбэрсэн тохиолдолд ямар дохио өгөх вэ, иргэд яаж өөрсдийгөө хамгаалах вэ гэдгийг гурав, дөрвөн яам, агентлагуудыг нийлүүлээд нэг ажил хийх гэсэн ерөөсөө явж өгдөггүй. Бие бие рүүгээ жихээд байдаг юм байна. Зарим байгууллагууд шилжүүлсэн бол илүү ажил хийхийг хүсдэггүй. Илүү ажил хийвэл шүүмжлүүлнэ. Эсвэл эвтэйхэн тэгсхийгээд байж бай ч гэдэг юм уу.

Тийм учраас төрийн байгууллагуудын хооронд яг дунд нь хаягддаг, бие бие рүүгээ шилжүүлдэг энэ юман дээр нь процессыг нь дахин инженерчлэлийн эрсдэлийнхээ үнэлгээг нэг дэлгэрэнгүй мэдээлэл байвал танилцуулж өгөөч ээ гэж хүсэж байна. Амжилт хүсье.

Х.Баасанжаргал: Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа.

Төрийн байгууллага гэлтгүй шилжүүлээ гэдгээр л асуудлыг хаагаад байна. Үүнийгээ хэдүүлээ яаж шийдвэрлэх вэ, яаж оноожуулах вэ гэдгээ их сайн бодмоор байна.

Ой санамжийн асуудал. Шинээр томилогдсон албан тушаалтан болгон бүх ажлыг чинь шинээр эхлүүлнэ. Тэнд очоод.

Төрийн бодлого, шийдвэрийн хүрээнд нөгөө талдаа тасралтгүй үргэлжлэх гэдэг концепцоороо биш өөрийнхөө үзэл бодлоор тэнд асуудлыг бүр бусниулж байна. Төрийн албан дээр. Үүнийгээ бид яаж шийдвэрлэх вэ гэдгээ хармаар байна.

Төрийн захиргааны биш мөртлөө төрийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа байгууллагуудтай холбоотой асуудлуудаа яах вэ. Төрийн өмчит компани, хөгжлийн төвүүд. Одоо Барилгын хөгжлийн төв гэх мэтчилэнгээр байгаад байна. Үүнийгээ хэдүүлээ яаж шийдвэрлэх вэ гэдгээ бас нэг тал руугаа гаргахгүй болохгүй байна.

Яах вэ, тэгээд л энэ Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар ажиллаад байна. Үр дүнд хүрч байгаа гэж ойлгож байгаа. Гэхдээ улс төрийн томилгоо, сайд дагасан томилгоо, намын томилгоо, энэ бүхнийг шийдээгүй цагт хэзээ ч энэ асуудал шийдвэрлэгдэхгүй. Ний нуугүй хэлэхэд. Мэдээж явах ёстой байх. Гэхдээ талдаа бид зүй зохистой харилцааг нь барихгүй бол болохгүй шүү дээ. Та хэд сая маш алдаатай үг хэллээ.

2022, 2023, 2024 онд намайг сайдаар ажиллаж байх цаг хугацаанд манай тухайн үеийн өмнөх төрийн нарийн нь. Дараагийнх нь биш. Төрийн албан хаагчдыг бүр хорин хэдээр нь халах гэж оруулж ирж байсан шүү. Тэр би бүр өөрөө сайдын хувьд зогсоож байсан процессууд байсан.

Төрийн мэргэшсэн албан хаагчдыг хоморголон халж ерөөсөө болохгүй. Болохгүй. Үүнийг тэр 2024 оны 7 сараас хойш гэдгийг Та бүхэн хэлээрэй.

Процессын дахин инженерчлэл хийсэн гээд байна. Түүн дээр ямар инженерчлэл хийснийг би ойлгохгүй байна.

Би өнөөдөр бодит жишээ хэлье. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Т.Золбаяр гэдэг залуу байна. Тэр –

- Төрийн нарийн бичгийн даргын ажилд ч оролцож байна.
 - Тусгай хамгаалалттай газар нутгийн даргын ажилд ч оролцож байна.
 - Бодлого, зохицуулалтын газрын даргын ажилд ч оролцож байна.
-

Энэ холбогдсон албан тушаалтнууд ямар чиг үүргийн дагуу юу хийхээ мэдэхгүйгээр сайдыг дагаж очсон гэдгээрээ төрийн албаны зарчим, дүрэм журмыг ингэж уландаа гишгэж болохгүй.

Тэр Т.Золбаяр гэдэг хүнийг дуудаж тэр асуудлуудыг нь ярих хэрэгтэй.

Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга хэрвээ бүгдийг нь шийддэг юм бол –

- Тусгай хамгаалалттай газрын бичгийн даргаар яадаг юм,
- Бодлого, зохицуулалтын газрын даргаар яадаг юм,
- Уур амьсгалын өөрчлөлтийн даргаар яадаг юм.

Тэгээд ер нь Төрийн нарийн бичгийн даргаар ч яадаг юм.

Тэр Т.Золбаяр гэдэг хүн бүх асуудлаа шийдээд явах хэрэгтэй шүү дээ.

Тэгэхээр энэ “процессын дахин инженерчлэл” гэдэг дотор чинь Та бүхэн тодорхой чиг үүргийн гүйцэтгэж байгаа ажил, үүргийнхээ хуваарилалтын хүрээнд –

- ажлаа хийж байгаа юу, үгүй юу,
- бусдын ажилд оролцоод байна уу, үгүй юу.

Тэнд бужигнуулдаг сайд дагаж очсон далдгануур хэдэн юмнаас болоод та хэдийн хийгээд байгаа энэ “процессын дахин инженерчлэл” чинь үр дүнд хүрэхгүй, эргээд иргэд хохирч байгаа хэлбэр яваад байна уу гэдгийг давхар хараасай гэж хүсэж байгаа юм. Бүр хүсэж байна. Энэ бол бодит нөхцөл байдал дээр байгаа шүү.

Тэгэхээр цааш цаашдаа та хэд “процессын дахин инженерчлэл” гээд хийж байгаа нь сайн. Гэхдээ байгаа оносон байгаасай гэж бодож байна. Байгаа онохгүйгээс улбаатай хэн нэгэн даргын өнгө үзэмжээс шалтгаантайгаар тухайн байгууллага доторх.

Байгаль орчны яам гэдэг тоглоом биш шүү. Энэ бол Монгол Улсын бүх хүрээлэн буй орчны асуудал. Үндсэн хуулиар олгогдсон хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрахтай холбоотой асуудал энд хөндөгддөг.

Гэх мэтчилнээс авахуулаад Та бүхний хийж байгаа ажил. Тухайлбал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Т.Золбаяр гэдэг хүн дээр очоод унаж байна.

Х.Баасанжаргал: Ж.Золжаргал гишүүн гишүүн.

Ж.Золжаргал: Өргөдөл, гомдлуудын их том хэсэг нь ахуй орчинтой холбоотой байдаг.

Жишээ нь, тэр нэг хорооллын байшингийн гадна талын талбайг яаж засах вэ гээд өргөдөл, гомдол гаргамаар байдаг. Өргөдөл, гомдлоо хааш нь гаргаа мэддэггүй. Улсын Их Хурал руу гаргадаг нэг тийм сонин жишигтэй.

Ахуйн асуудалтай тэр өргөдөл, гомдлыг хамгийн түрүүнд авч хэлэлцэх боломжтой хүмүүс нь хороо. Тэгээд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

Хороон дарга нь хаачсан гэсэн чинь улс төрч болсон. Олдохгүй. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлынхан бас улс төрч. Нам намаараа сонгуульдаад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаа байгуулаад явдаг.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлынхан бүгдээрээ компанийн дарга, захирлууд болсон. Одоо нэг Улсын Их Хурлын гишүүн нэг төрийн өмчийн цахилгаан станцын дарга болсон. Тэгээд эрчим хүчний шинэчлэл яриад яваад байж болдоггүйтэй адилхан л юм байхгүй юу.

Бүх төлөөлөгч нар нь бүгдээрээ нэг компанийн дарга болсон. Захирал болсон. Тэгээд иргэдийн төлөөлөл болоод иргэдийн төлөөллийн асуудлыг ярилцах гэхээр өргөдөл, гомдлоо ярих завгүй. Тэгэлгүй яадаг юм. Тэр чинь засгийн ажил шиг л битүү аж ахуйн ажил хийгээд явж байгаа хүмүүс чинь арга ч үгүй их л ачаалалтай ажиллаж байгаа байх. Энэ хоёрыг нь салгамаар байгаа юм.

Тэгэхээр энэ иргэдийн төлөөлөгч иргэдийн төлөөлөгчөө хийхгүй засгийн гүйцэтгэх ажил хийгээд байхаар иргэдийн төлөөллөө хийж чадахгүй байна. Нэг асуудал шийдэж байж бид өргөдөл, гомдлыг авч хэлэлцдэг субъектүүдийг жоохон завтай болох юм шиг байна.

Хоёрдугаарт нь, нэгжийн тухай хууль дээр тухайн нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдийн 5 хувиас дээших нь нэг санал гаргах юм бол тэрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал авч хэлэлцэх үүрэгтэй. Тэгээд түүн дээр ажиллаж байгаа намууд алга.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль дээр намаараа хуваагдаж санал өгөх л юм бол намууд нь очиж ажиллаач дээ. Ажиллахгүй бол иргэдийн төлөөлөгчийг намаас холдуулъя. Өөр шууд тэндхийнх нь оршин суугч, аж ахуйгаа мэддэг хүмүүсийг нь сонгодог.

Нэгэнт намтайгаа ажиллаж байгаа бол намууд тэнд очиж зохион байгуулалтаа хийж иргэдүүдийн асуудлыг нь судалж, 5 хувиас дээших тэр санал

гаргаад байгаа гарын үсгүүдийг нь багцалж өгөөд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг нь хуралдуулаад, төсөв хуваарилалтаа тэндээсээ гаргаад явмаар байна.

Энэ нь нээгдэхгүй болохоор асуудал нь хаашаа очихоо мэдэхгүй хана мөргөөд. Тэр нэг орцны шатны плита солих асуудал Засгийн газар луу, Улсын Их Хурал руу орж ирээд байна.

Энэ асуудлыг ингэж хүмүүстэй уулзаж яваад ер нь тийм юм байна гэж дүгнэхээд өнгөрсөн жил бид 4 дүгээр сард энэ цахим оролцооны талаар нэг хэлэлцүүлэг хийж байсан шүү дээ. Иргэдийн хүсэл гомдлын талаар.

Түүнээс хойш, ер нь түүнээс дүгнэлт гаргаад Нэгжийн тухай хуулийн иргэдийн оролцоог цахимаар оролцох нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслийг боловсруулж бэлэн болгоод, зарим гишүүдтэй хамтарч өргөн барья гээд явж байгаа. Гарын үсэг зуруулаад.

Тэгээд одоо d-petition ажлын журмын талаар энд нэг Өргөдлийн байнгын хорооны ажлын хэсэг гарчхаад явж байгаа. Үүнийхээ дүгнэлт дээр нэмж оруулаад үүнийг ер нь яаралтай өргөн барих зүйтэй гэж бодож байна.

Тэгэхгүй бол нийтийн өргөдлийн хамгийн том хэсэг буюу ахуйн орчинтой холбоотой асуудлыг хэлэлцдэг хороо, сум, иргэдийн төлөөллүүд аж ахуйн ажилдаа дарагдаад, ялангуяа нийслэл бол дарга нар болчихоод, компанийн захирлууд болчихоод олдохоо байчихаад байна.

Үүнийг цэгцлэх юм бол өргөдөл, гомдлын асуудал дээр нэлээн том нааштай шийдвэр болно гэж үзэж байна.

Х.Баасанжаргал: Д.Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Тийм ээ. Тэр “процессын дахин инженерчлэл” гэдэг энэ зүйлийг Засгийн газрын энэ хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрсдөөсөө эхлэхгүй бол болохгүй болжээ.

Сая асуулт, хариултын явцад яригдлаа. Тийм ээ. Хариуцаж байсан хүн нь телевизээр ярьж байсан. Чуулган дээр хүртэл яригдсан. Авлигатай тэмцэх газар дээр хүртэл очсон. Хэрэг үүссэн. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр хүртэл очсон гээд байгаа.

Тэгтэл ажил авсан дараагийн улсууд нь энэ талаар ямар ч мэдээлэл байхгүй. Манай урьдын хүмүүс бид нарт ажил хүлээлгэж өгөөгүй гэдэг байдлаар ярьж байгаа нь төрийн байгууллагын өнөөгийн байдлыг л харуулаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр “процессын дахин инженерчлэл” гэдэг юм чинь энэ дээрээ хийгдэхгүй бол хийгээд л байдаг, хийгээд л байдаг, хийгээд л байдаг, нэг жилийн дараа дараагийн байгууллага нь, дараагийн хүмүүс нь томилогдож орж ирээд л ямар ч ажил байхгүй. Бүгдийг нь ахиад шинээр эхлэх хэрэгтэй болчихож байна.

Тэгээд би нэг хүний мууд дурлаад байгаа юм биш л дээ. Тэгээд бүхэл бүтэн нэг аймгийн Засаг даргыг алдаа гаргажээ, жаран хэдэн тэрбум төгрөгийн зөрчил гаргажээ гэдэг байдлаар нь дүгнэлт гарчхаад, тэгэнгүүтээ ахиад яасан нь мэдэгдэхгүй алга болдог. Алдаа гаргаагүй, ямар нэгэн зөрчилгүй юм тэр хүний тэр нэр төрийг нь заагаад байх хэрэгтэй. Ямар нэгэн асуудал байгаа бол тэрийг нь мухарлах ёстой. Тодорхой хэмжээний хариуцлага яригдах ёстой.

Тэгээд энэ асуудал хаана яригдах вэ гэхээр яг энэ төрийн байгууллагыг чинь дахин дахин л яриад байна шүү дээ. Та сая яг энэ төрийн байгууллагуудын энэ “процессын дахин инженерчлэл” гэдэг үгийг маш их ярьж байна. Өгүүлбэр болгондоо бараг ярьж байна шүү дээ.

Тэгэхээр та өөрийнхөө үйл ажиллагаандаа оруулах хэрэгтэй байх. Багагүй хугацаа өнгөрлөө. Хагас жил гэдэг бол.

Байгаль орчны яаман дээр бүр үр дүнтэй хийсэн гэж ярьж яригдаж байна. Урьд нь ажил хариуцаж байсан сайд нь тодорхой хэмжээгээр коммент хэлж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ та анхаараад энэ өргөдөл, гомдолтой холбоотой, тэр Дарханы Засаг даргатай холбоотой тэр дүгнэлтийн талаар та мухарласан нь дээр ээ. Тэгээд яг юу болсон юм, хаана юу алдагдсан байгаа юм бэ, ямар байдалтай байгаа юм бэ гэдгийг Та надад яг өөрөө мэдэгдсэн нь дээр гэж хэлье.

Х.Баасанжаргал: О.Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Өргөдөл, гомдлын асуудал их ярих хэрэгтэй болоод байгаа.

Яагаад өргөдөл, гомдол гаргагчийг хүн ам зүйн мэдээллийг тодруулах хэрэгтэй гэхээр хэний асуудал шийдэгдээд, хэний асуудал шийдэгддэг вэ гэдгийг бид харах хэрэгтэй байгаа гэсэн үг.

Иргэд парламентад өргөдөл гаргахын тулд, хэлэлцүүлэхийн тулд 33 мянгын гарын үсэг зуруулах ёстой гэдэг. Энэ 33 мянга гэдэг тоо нийгмийн эмзэг бүлэг, цахим хуваагдалд өртөөд байгаа малчид ч юм уу, хүртээмжгүй технологийн газар, тийм газар байгаа хүмүүст энэ боломжгүй. Гэхдээ энэ нь боломжгүй гэдэг нь тэд нарын асуудал биш гэж орхигдох ёсгүй байхгүй юу.

Малчдын асуудал шийдэгдэж байна. Өнөөдөр цахим хуваагдалд орж байгаа шүү дээ. Зарим утгаараа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал шийдэгдэж байна уу. Би л лав шийдэгдэхдээ муу л байна гэж бодоод байгаа. Яагаад гэвэл би өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн болсноосоо хойш иргэдээс бараг мянга орчим санал, хүсэлт авсан. Зарим нь сонсоод өгмөөр л асуудал байдаг.

Гишүүнтэй уулзаж яримаар байна гээд сонсохоор –

- баг нь шийдэж болохоор,
- хороо нь шийдэж болохоор,
- дүүрэг нь шийдэж болохоор,
- агентлаг нь шийдэж болохоор,
- яам нь шийдэж болохоор асуудлууд байгаад байдаг.

Яагаад та заавал надтай уулзаж ингэж ярих гээд байгаа гэхээр энэ хүмүүс

–

- намайг сонсохгүй байна,
- миний өргөдлийг хүлээж авахгүй байна,
- хүсэлтийг минь ойшоохгүй байна л гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр бид хаа хаанаа энэ шинэчлэл хийж байгаа л бол хүртээмжийнхээ асуудлыг нэгдүгээрт нэн яаралтай тоолж үзээд, аль нь дутуу байгааг сайжруулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, хүн ам зүйн үзүүлэлтээр нь гаргах хэрэгтэй байна. Хэний асуудлыг шийдээд, хэнийх шийддэггүй вэ гэдгийг өнөөдөр бид улсаараа харах хэрэгтэй гэсэн үг.

Хоёрдугаарт, “Цахим Монгол” гээд болж байгаа шүү дээ. Тийм ээ. “Цахим Монгол” гээд бид зөндөө ярьж байгаа. E-mongolia маш сайн. E-mongolia руу ороод үйлчилгээ авах гэхээр зөндөө цэс, мэдээллүүд нь байж байгаа. Гэхдээ нөгөө талд ингэх тусмаа мэдээлэл авч байгаа хүнд, өргөдөл, гомдлоо өгч байгаа хүнд зарим утгаараа энэ хүртээмжгүй болчихоод байгаа.

Нэг дарга очоод л нэг байгууллага солигдоод л нэг юм нь гацдаг. Нэг ийм асуудал байна.

Тэгэхээр энэ цахим хүртээмжтэй буюу тэр user-friendly буюу хэрэглэгчдэд ээлтэй гэдэг энэ юмаа бид нэг талдаа гаргаж цэгцлэхгүй бол энэ асуудлууд, өргөдлүүд нь байгаа л байна. Эсвэл өргөдлөө өгч чадахгүй хүмүүс тэндээ асуудал нь улам хүндрээд яваад байгаа гэсэн үг.

Хэрвээ Та бүхэн өмнө нь гадаад, дотоодод зорчиж байгаа явсан өчнөөн л хүмүүс байдаг байх. Жишээлбэл, Канадын ч юм уу, зарим нэг Скандинавын орнуудын хотын вебсайтыг ороод үзэхээр яг иргэдэд зориулсан үйлчилгээний цэсээр байдаг. Аж ахуйн нэгж хаанаас ямар зөвшөөрөл авах вэ, яах вэ гэдэг шиг аж ахуйн нэгжийн тухай байдаг. Зөвшөөрлийн тухай байдаг. Гудамж гэнгүүт гудамжны асуудлууд байж байдаг. Ерөөсөө л хүн л ороход аягүй ээлтэй байгаад байдаг.

Манай улсын төрийн байгууллагын сайтууд ямар байдаг вэ гэхээр –

- эхлээд нэг даргын мэндчилгээ байдаг.
- Тэгээд солигдсон даргынх нь зурагтай байж байдаг.
- Тэгээд иргэдийн санал, хүсэлт гээд буланд нь нэг жижигхэн асуулт тавиад сэтгэл “ханамжтай”, “ханамжгүй” гэдгийг нь асуусан хэлбэртэй.

Яг юунд ханаж байгаа, үгүйгээ мэддэггүй. Нэг “од” дугуйлна. 1-ээс 5-тай. Ийм л юм байгаа.

Тэгээд энэ дээрээ үр дүн гаргаад “ханамжтай байна” гээд тайлан гаргасан. Ийм хүртээмжгүй.

Тэгээд яг үнэндээ тэр вебсайт руу хүмүүс яагаад ордог вэ гэхээр өөрт хэрэгтэй мэдээллээ хайдаггүй байхгүй юу.

Бизнесийн байгууллага өнөөдөр зүгээр хаалгаар нь ороход “дугаар авах үйлчилгээ” тэнд байна гээд хаягтай байдаг шиг манай төрийн үйлчилгээний сайтууд тийм баймаар байгаа юм. Төрийн үйлчилгээ рүү хүн “татвар” гэж асуух гэж байгаа бол “аж ахуйн нэгжийн тайлан” гэдгийг харах гэж байгаа бол тэр нь нүүрийн эгнээнд нь байдаг. Үүнийг бид “вебсайтын хүртээмж” гэж яриад байгаа.

Тэгэхээр ийм баймаар байгаа. Энэ хуучин хандлагаа солих нь аягүй чухал. Үүний цаана нөгөө л хүртээмж ярьж байгаа. Энэ хүртээмжийг сайжруулсан газар ядаж гомдол нь багасаад, үйлчилгээ илүү хүндээ хүрнэ шүү дээ.

Тэгэхээр энэ дээр анхаарахыг сануулъя.

Х.Баасанжаргал: Би эцэст нь дүгнээд гурван санал хэлье.

Манай Байнгын хороо яг энэ мэт иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг бид яг энэ байдлаар тогтмол сонсоод, илүү сайжруулах, илүү хамтрах тал дээрээ бүгдээрээ үндсэн гол механизм тал дээрээ ажиллая гээд манай Өргөдлийн байнгын хороо Та бүхнийг өнөөдөр дуудаад мэдээллийг авч байгаа.

Цаашид үүнийг тогтмолжуулъя гэсэн саналтай байгаа. Тэр дундаа ялангуяа сая Та бүхнээс гаргасан салбаруудаар өргөдөл, гомдол гарч байгаа мэдээллүүдийг харахаар салбар, салбар, чиглэл чиглэл хариуцсан Байнгын хороодод та нар энэ мэдээллийг өгдөг баймаар байна гэж бодож байна.

Жишээ нь, Хууль зүйн байнгын хороон дээр яг энэ хууль зүйн салбартай холбоотой иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдлын мэдээллийг өгөөд, буцаад хууль зүйн салбарын төрийн байгууллагуудтай. Эргээд Хууль зүйн байнгын хороо энэ асуудлаа сонсдог, ярилцдаг, хэлэлцдэг байх горимыг үүсгэх ёстой болов уу гэж харж байна.

Тэгэхгүй бол бид энэ дээр жишээ нь хуулийн салбарын, эрүүл мэндийн салбарын иргэдийн өргөдөл, гомдлыг хэлэлцээд байх чинь өөрөө бид нарт зарим нь чиг үүрэгт хамаарна, хамаарахгүй гээд олон асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ дээр эргэж бүгдээрээ ярилцах ёстой байна.

Тэгэхээр бусад Байнгын хороодод энэ мэдээллийг илүү салбар салбараар нь детал байдлаар өгөх дээр бүгдээрээ анхаараад ажиллая гэж бодож байна.

Тэгээд ялангуяа би өөрөө хуулийн салбарын тоонуудыг хараад сууж байхад хууль, шүүх, цагдаа гээд нэг багцлаад “хууль эрх зүй” гээд багцлаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр шүүх эрх мэдлийн байгууллагууд чинь энэ дунд чинь холилдоод яваад байгаа юм биш биз дээ гэдгийг нэг ялгах хэрэгтэй болж таарах байх. Нэг ийм санал.

Хоёрдугаарт, түрүүн С.Эрдэнэбат гишүүн хэлсэн. Өргөдөл, гомдлын тоо нэмэгдэх гэдэг нэг тийм муу үзүүлэлт биш.

Таван жилийн үндсэн чиглэл дээр, ялангуяа манай Байнгын хорооноос гарсан нэг гол үндсэн санал юу гарсан бэ гэвэл иргэдээс –

- өргөдөл, гомдлоо шийдвэрлүүлж байгаа,
- тэр эрх хангагдаж байгаа байдал буюу –

-нэг удаа өргөдөл, гомдлоо гаргаад “асуудлаа шийдвэрлэж чадаж байгаа” тэр тоог “чанарын тоо” гэдгээр таван жилийн үндсэн чиглэл дээр оруулсан юм. Үзүүлэлт дээрээ.

Түүнээс биш шийдвэрлэгдэж байгаа өргөдөл, гомдлын тоо буурсан байдал гэвэл энэ чинь өөрөө буруу тийшээ явах байхгүй юу. Нөгөө бүртгэхгүй рүүгээ орно. Нуух, хаах руугаа орно. Тийм ээ.

Тэгэхээр хэдүүлээ энэ нюансуудаа аягүй сайн гаргаад. Та хэд мэргэжлийн хүмүүс учраас энэ дээр анхаарах ёстой байх.

Тэгэхээр өргөдөл, гомдлын ирж байгаа, ялангуяа тоо, ялангуяа салбарууд дээр ямар асуудлууд дээр дахин дахин гараад байна вэ гэдэг дээр л хамгийн гол анализ хийх ёстой болов уу гэж харж байна.

Тэгээд манай Байнгын хорооны дараагийн нэг хийх ёстой ажил Б.Номинчимэг даргыг ирэхээр үүнийг уламжилъя.

Энэ иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн асуудлыг шинэчлэхгүй бол одоо яг ингээд л бид сонсоод л дуусах гээд байгаа юм. Ямар ч үр дүнгүй гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр илүү энэ хууль тогтоомж яаж сайжрах юм, яаж байж шийдвэрлэсэн гэдэг рүү орох юм. Нөгөө “шилжүүлсэн” нь өөрөө “шийдвэрлэсэн” гэдэг тоо руу ороод л. Бид энэ тоонд хууртаад л байх юм бол ямар ч үр дүн байхгүй гэсэн үг.

Тэгэхээр чуулган магадгүй завсарлахаар манай Байнгын хорооны нэг анхаарах ёстой ажил бол Иргэдээс төрийн байгууллага, албан албан тушаалтанд гаргаж байгаа өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, багтаагаад Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь давхар явах уу, эсвэл энэ дотроо нэг бүлэг болгож оруулах уу, үгүй юу гээд манай Байнгын хороо яг энэ асуудлуудыг багцалж хариуцах ёстой болов уу гэж харж байна.

Тэгээд зарим нэр бүхий гишүүдээс Дархан-Уул аймгийн Засаг даргатай холбоотой асуудлаар тусгайлан мэдээлэл өгөөрэй гэлээ. Тэгээд энэ тухай мэдээллээ манай Байнгын хорооны гишүүдэд өгөх, нарийвчилсан мэдээллүүдийг Та бүхэн гаргаад мэдээллүүдээ эргэж холбоотой ажиллаарай гэж хүсье.

Тэр хүртээмжийн асуудал дээр санал нэг байна. Ялангуяа хүртээмжийн асуудал дээр, Ж.Золжаргал гишүүн бид хэдийн ажиллаж байгаа d-petition дээр нэг зүйл харагдаж байгаа байхгүй юу. D-petition гээд өгсөн нэр нь өөрөө энэ сайтыг хүртээмжтэй болгоход хамгийн саад болж байна. D-petition гээд тэмдэгттэй нэр. Тийм ээ.

Тэгэхээр яг хөдөө орон нутгийн малчид жишээ нь d-petition гээд өргөдлөө өгнө гэдэг бол энэ нэр нь өөрөө хүндрэл үүсгээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ мэтчилэн хэдүүлээ хүртээмжийн асуудал дээр ч гэсэн дараагийн удаа мэдээлэл сонсох дээр илүү энэ дээр байгаа зарим мэдээллүүдийг нарийвчлаад, тэгээд төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрууд дээр ирж байгаа өргөдөл, гомдлуудын тоог тусдаа гаргаад, тэгээд хүртээмжийн үнэлгээтэй нь гээд ингээд хэдүүлээ дахиж яг энэ мэдээллүүдийг нарийн сонсдог болъё. Үүнийг тогтмолжуулъя.

Дээрээс нь бусад Байнгын хороодод энэ мэдээллийг өгдөг байх зүйлийг хэдүүлээ анхаарч ажиллая гэж хүсэж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх, асуулт асуух гишүүд үг хэлж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүддээ маш их баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэх

Хоёр.Өргөдлийн байнгын хороонд Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлэлцэж эхэлье.

Хамгийн эхний өргөдлийг бид нээлттэй хэлэлцэнэ. Хоёр дахь өргөдлөөс эхлээд бид хаалттай хэлэлцэх горимын санал гаргаад бүгдээрээ санал хураалтаар шийдвэрлэнэ.

Яагаад санал гаргаж байгаа вэ гэвэл хуралдаанд оролцогчийн зүгээс гаргаж байгаа санал.

Хувь хүний хувийн мэдээллүүд маш их агуулагдсан өргөдөл, мэдээллийн тухай бид дан ярих учраас хоёр дахь өргөдөл, гомдлоос хойш асуудлыг бүгдээрээ хаалттай хэлэлцье гэдэг горимын санал дээр санал хураалт явуулна.

Хамгийн эхний өргөдөл. Бидний нээлттэй хэлэлцэх өргөдөл бол Улсын Их Хурлын удирдлага болон Өргөдлийн байнгын хороонд Ахмадын дуу хоолой хөдөлгөөний зохицуулагч Ц.Алтанзул нарын 18 иргэн, мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Ахмадын холбооны гишүүн н.Санжаа Монголын ахмадын холбооны удирдах зөвлөлөөр уламжлуулан Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Ахмадын хорооны дарга М.Бямбаа, Мандал сумын Ахмадын хорооны удирдах зөвлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл болон Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаар уламжлуулан Монголын ахмадын удирдах зөвлөл болон

Ахмадын дуу хоолой хөдөлгөөний ахмадуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, шаардлагын хүрээнд Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолоор ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, П.Мөнхтулга нар ажилласан.

Ингээд Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах асуудлаар ирүүлсэн ахмадуудын өргөдлийг судлаад санал, дүгнэлт гаргах Ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Та бүхэнд товч танилцуулга хийнэ.

Ажлын хэсгийн гишүүдийг урья. Хэлэлцэж байгаа өргөдөлтэй холбоотой ажлын хэсгийн гишүүд.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул байна уу, ирсэн үү, ирэх үү, орж ирэх үү. Орж ирэхгүй бол сайд нь орж ирээгүй учраас гээд хэрвээ Л.Мөнхзул дарга орж ирэхгүй бол энэ асуудлыг хойшлуулна гэсэн үг.

Дараа нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Н.Рэнцэнханд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч С.Жаргалсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч Э.Цэрэнбат, Нийгмийн даатгалын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц хариуцсан мэргэжилтэн Б.Баярболд.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулж дууслаа.

С.Эрдэнэбат гишүүний танилцуулгыг сонсьё.

С.Эрдэнэбат: Энэ Монголбанкнаас ирээгүй юм уу? Тийм ээ.

Гол асуудал шийдэх субъект нь Монголбанк байсан юм. Тэгэхдээ яах вэ, би нэмэлтээр товчхон танилцуулъя гэж бодож байна.

Ахмадын дуу хоолой хөдөлгөөний зохицуулалт Ц.Алтанзул, Ахмадын холбоо, мөн нэр бүхий бараг 2700 хүн гарын үсэг зурсан өргөдөл ирсэн.

Тэгээд Д.Рэгдэл гишүүн, П.Мөнхтулга гишүүн бид гурвыг ажлын хэсгээр томилоод –

- зээлийн хүүг бууруулах,
- тэтгэврийн зээлийн хугацааг уртасгах,
- тэтгэврийн хэмжээг сая 500 болгох,
- ахмадын асрах сувилах, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах –

гээд 4 багц асуудал байсан.

Энэ чиглэлээр нь бид багагүй хугацаанд ажилласан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, Сангийн яам, Монголбанк, Эдийн засгийн хөгжлийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын банкнуудын холбоо, мөн арилжааны банкнууд зэрэг байгууллагуудтай уулзаад, мөн төсөв хэлэлцэж байх үетэй зэрэгцэж асуудал орсон учраас Өргөдлийн байнгын хороогоор ахмадын тэтгэвэр нэмэгдүүлэх асуудлыг хүртэл Төсвийн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо.

Өргөдлийн байнгын хороо ямар ч байсан үүнийг дэмжиж Их Хуралд тодорхой зарчмын зөрүүтэй санал болгож гишүүд санал оруулсан.

Энд ахмадын тэтгэврийн асуудлыг ямар ч байсан зарчмын хувьд сая 500 мянган төгрөг болгох гэдэг асуудал нь өөрөө “доод хэмжээг нэмэгдүүлэх” гэдэг асуудал байсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төсвийн байнгын хороо, Сангийн яам зэрэг байгууллагууд доод тэтгэврийг сая 500 болгох юм бол нийтдээ ойролцоогоор 3 их наяд орчим төгрөг шаардагдана. Эдийн засгийн боломж бололцоо байхгүй гэдэг нэгдүгээрт асуудал ярьсан.

Хоёрдугаарт нь, дунд болон өндөр тэтгэвэртэй ахмадууд хэрвээ доод тэтгэвэр ингэж шууд дээш нь болгох гэдэг бодлого барих юм бол бидний эрх ашиг зөрчигдөнө. Өөрөөр хэлбэл яг сая 500 мянган төгрөг авч байгаа ахмадууд, мөн түүнээс дээшээ авч байгаа ахмадууд өндөр тогтоолгосон, өндөр шимтгэл төлөх шаардлага байна уу гэдэг зөрчилтэй асуудал дунд нь яригдсан гэдгийг би тодруулж хэлмээр байна.

Тэгээд ямар ч байсан эцсийн байдлаар болохоос нь болохгүй хүртэл Байнгын хороод болон Засгийн газарт асуудлыг уламжилсан.

Мөн Ерөнхий сайд, Их Хурлын дарга, яамдын сайд нартай удаа дараа уулзсан. Тэгээд ямар ч байсан ахмадын тэтгэвэртэй холбоотой зарчмын зөрүүтэй саналууд хүртэл гаргасан.

Тэгээд эцсийн байдлаар анх төсөл дээрээ 6 хувиар нэмэгдүүлнэ гэж орж ирж байсан энэ хэмжээ инфляц гэдэг зүйлээсээ дээш байх учраас тухайн үед сарын өмнө мөрдөгдөж байсан 8.6 хувиар нийт санг нь нэмэгдүүлээд, одоо эцсийн байдлаар тодорхой мөнгөн дүнгээр нэмнэ гээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр хувилбар яригдаж байгаа юм байна.

Засгийн газар эцэслэж шийдэх ёстой учраас яг эцэслэн үүнийг яг тэдэн төгрөгөөр нэмэгдэнэ гэдэг нь шийдээгүй. Одоо яг эцэслэн шийдэгдээгүй байна гэж би ойлгож байгаа.

Монголбанк өнгөрсөн долоо хоногийн тав дахь өдөр. Их Хурлын дарга ч гэсэн энэ дээр ач холбогдол өгч Монголбанканд тэтгэврийн зээлийнх нь хугацааг сунгах буюу 36 сар хүртэлх хэлбэрээр олгож болох хувилбарыг арилжааны банкуудтай ярилцсан.

Энэ нь би нааштай шийдвэртэй юм байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 12 сарын 11 гэдэг чинь нөгөөдөр. Тийм ээ. Нөгөөдөр эргэж авч хэлэлцэнэ гэдэг байдлаар ярилцсан байна лээ.

Үүнийг манай ахмадууд буруугаар ойлгоод тэтгэвэр нэмэх гэж байхад зээлийн хугацааг уртасгалаа гээд яриад байна лээ.

Тэгэхээр 4 шаардлагынх нь нэг нь шүү. Тэтгэвэр нэмэх асуудал нэг асуудал нь.

Хоёрдугаарх нь, урт хугацааны зээлийн хугацааг хязгаарласан. Анхных нь шийдвэр ер нь яасан бэ гэхээр бүх ахмадуудын тэтгэврээс 495 мянган төгрөгийг хасаад, үлдсэн дээр нь л зээл олгоно гэдэг шийдвэр гарсан байсан шүү дээ. Энэ асуудал шийдэгдсэн. Өөрөөр хэлбэл энэ бол хэтэрхий чанга шийдвэр байна. 600 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа ахмадууд үндсэндээ 180 мянган төгрөгт нь л зээл олгоно гэдэг ийм хатуу мөнгөний бодлогын хорооны шийдэл буюу арилжааны банкууд очсон байсан. Үүнийг цуцалсан. Дараа нь 24 хүртэл буюу 18 сар хүртэл болгосон. Тэгээд сүүлд нь 36 болсон гэдэг асуудал байсан.

Тэгэхээр энэ дээр хэлэхэд цаашдаа бид ахмадын тэтгэврийн зээлийн хугацааг нь нэмнэ гэхээсээ илүү тэтгэврийг нэмэгдүүлэх, хүүг нь багасгах гээд.

Одоо манай зарим гишүүд ч гэсэн бид ярилцаад ер нь хүүг нь тодорхой хэмжээгээр хязгаарлах, маржийг нь багасгах гэдэг асуудал дээр саналууд гаргаад явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Ахмадын эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой том асуудал. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон зарчмын зөрүүтэй санал би гаргасан. Ахмадуудыг асрах, сувилах үйлчилгээндээ нэмэлтээр мөнгө тавиулсан. Улсын

төсөвт анх удаагаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 7 тэрбум. Миний бие ч гэсэн зарчмын зөрүүтэй нэмэлт санал гаргаад, ялангуяа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртсөн ахмадуудыг асрах, сувилах үйлчилгээг, гэрээр үйлчлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор нэмэлт төсвүүдийг тавиулсан.

Эрүүл мэндийн даатгалын хувь дээр эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой асуудал бүрэн шийдэгдээгүй. Шийдлээ хүлээж байгаа. Даатгал алдагдалтай байгаа. Зарим төрлийн үйлчилгээнүүд нь жоохон хязгаарлагдмал асуудал байгаа гэдгийг би онцлоод хэлмээр байна.

Тийм учраас Өргөдлийн байнгын хороо өөрсдөөс шалтгаалах ажлуудаа тодорхой хэмжээнд хийсэн. Би боломжийн хэмжээнд бараг үндсэндээ өргөдөл өгөөд нэлээн удлаа. Тийм ээ. Өөрөө том асуудал байсан учраас Өргөдлийн байнгын хорооны гишүүд бүгдээрээ энэ ахмадын тавьсан асуудлыг дэмжиж ажилласан шүү гэдгийг би онцолж тэмдэглэмээр байна.

Товчхон хэлэхэд санал ийм байна.

Ер нь нэг доор өргөдөл өгөөд шийдэгддэг асуудал биш. Жил болгон л гарах байх. Ирэх жил гэхэд дахиад л тэтгэврийн асуудал яригдана.

Монгол Улсыг хөгжүүлэх 2026-2030 оны хөгжлийн хөтөлбөрт зарчмын зөрүүтэй санал гаргаад, ахмадын тэтгэврийг энэ жил болгон тодорхой хувиудаа тавиад, ер нь ирэх жилүүдэд доор хаяж 70-аас доошгүй хувиар доод ахмадын тэтгэврийг нэмэгдүүлье. Ирэх 5 жил гэдэг шийдэл, чиглэлийг нь гаргаад өгсөн.

Тийм учраас жилд ер нь хэдэн хувиар нэмэгдэх вэ гэдэг нь нэг тийм жагсаал цуглааны байдалтай, гэнэтийн шаардлага байдалтай биш үндсэн чиглэлд тодорхой тавигдаад явах хэрэгтэй.

Ер нь ахмадын доод тэтгэврийг амьжиргаанд нь хүрэлцэхүйц гэдэг дээр энэ үндсэн чиглэл дээр тодорхой хувь хэмжээ болон юун дээр нь манай яамныхан давхар хариулах байх. Ийм зүйлийг нэмээд хэлмээр байна.

Х.Баасанжаргал: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух, үг хэлэх хоёрыг хамт явъя. Гишүүд байвал саналаа өгнө үү?

Д.Батбаяр гишүүнээр тасалбар болгоё. Ө.Шижир гишүүн. Д.Батбаяр гишүүний микрофоныг.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Тэгээд ихэнх асуудлууд нь сая төсөвтөө хэлэлцэж байх үеэр шийдэгдсэн байгаа. Тэгээд өргөдлийн товч агуулга дээр дурдагдаад байгаа энэ асуудлаа тодруулга авъя. Б.Батжаргал даргаас.

Энэ дээр ахмадуудын асрах үйлчилгээг сайжруулах талаар Ц.Алтанзул нарын 18 иргэнээс өргөдөл гаргасан байна.

Тэгэхээр жил болгон тендер зарлаад асрамж, сувиллын газруудаар ахмадыг хүлээж авдаг. Манай ахмадууд жилдээ нэг удаа үйлчлүүлэх эрхтэй байдаг. Тэгээд орон нутгаар явж байхад ахмадууд яг энэ потёк буюу энэ амрах эрхийн бичгийг л их сурагласан байдалтай байдаг юм. Тэгээд жилээс жилд багасаж байгаа. Очиж сувилуулдаг, амардаг энэ газрууд улам багасаад байгаа гэдэг зүйлийг ярьдаг.

Тэгэхээр энэ ахмадуудын асрах үйлчилгээний талаар Нийгмийн даатгалын газраас ер нь ямархуу бодлого бариад байгаа юм бэ? Энэ дээр ер нь Сангийн яаманд та нар төсөвтэй холбоотой, санхүүжилттэй холбоотойгоор ямар санал гаргадаг юм? Та хэдийн өөрсдийн барьж байгаа бодлого ер нь ямар байгаа юм? Яг энэ ахмадыг асрах үйлчилгээг дэмждэг ямар ямар байгууллагуудтай ер нь хамтарч ажилладаг юм? Энэ дээр хувийн хэвшлийг ямархуу байдлаар ер нь оролцуулах бодлого баримталж байгаа вэ?

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн хэддүгээр микрофон. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын ерөнхий газар. Б.Батжаргал.

Нийгмийн даатгалын багц хууль буюу багц 4 хуульд зааснаар ахмадтай холбоотой ахмадын ахмадын сувиллын асуудал үйлдвэрлэлийн ослын даатгалтай холбоотойгоор тавигддаг.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авдаг хүмүүсийн хувьд өнөөдрийн байдлаар 11 сувилалд хөдөлмөрийн чадвараа сэргээн засах боломжийг энэ онд бүрдүүлсэн. Хуучин 4-хөн сувилалд байсныг бид 11 сувилалд болгож өргөжүүлсэн байгаа.

Дараагийн бодлого энэ баруун талд байгаа баруун аймгуудын сувилал. Энэ өрсөлдөөнд цөөхөн орж ирдэг. Энэ оны хувьд Өвөрхангай аймаг анх удаа Хужиртын сувилал орж ирсэн.

Бидний барьж байгаа бодлого аль болох баруун талдаа Ховд аймагт, Баян-Өлгий аймагт, Увс аймагт, Завхан аймагт, Говь-Алтай аймагт энэ сувиллууд

байдаг бол энэ өрсөлдөөнд оруулж ирээд хол явж сувилуулах биш аль болох тухайн орон нутагтаа илүү чанартай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор ажиллаж байгаа.

Гэхдээ мэдээж Багануур, Эрдэнэт, Дарханд байгаа сайн сувиллууд руу очъё гэвэл бид холбогдох бүх зардлыг нь үйлдвэрлэлийн ослын сангаас хувьсах зардал хэлбэрээр болон унааны зардлыг нь гаргах үйлчилгээг бид үзүүлж байгаа. Баярлалаа.

Х.Баасанжаргал: Д.Батбаяр гишүүний микрофон. Тодруулъя.

Д.Батбаяр: Үйлдвэрлэлийн осолтой холбоотойгоор ахмадуудыг сувилж байгаа гэж байна.

Сүүлийн 2 жилээр Та статистик хэлэх боломж байна уу? Ер нь санхүүжилтэд хэдэн төгрөг гаргасан, хэдэн ахмадууд үйлчилгээ авсан. 2024, 2025. 3 жилээр нь. 2023 он гээд. Та үүнийг нь гаргаад өгчих.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Б.Батжаргал: Үйлдвэрлэлийн ослын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авдаг хүмүүсийн тоо хамгийн оргил үедээ 4 мянгад хүрч байсан.

Одоо манайд байгаа мэдээллээр 3800 орчим хүний мэдээлэл байгаа. Энэ бол зөвхөн Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа буюу үйлдвэрлэлийн ослын сангаас тэтгэвэр авдаг хүмүүсийн хувьд ярьж байгаа.

Дараа нь халамжийн сантай холбоотой тусдаа үйлчилгээ байдаг. Энэ үйлчилгээг манай халамжийн асуудал хариуцсан нэгж мэдээлэл өгсөн нь зөв болов уу гэж бодож байна.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

В.Рэнцэнханд: Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Ахмад настны тухай хуулийн дагуу ахмад настанд жилд нэг удаа ахмадын зориулалттай амралт сувилалд сувилуулдаг.

Мөн магадлан итгэмжлэгдсэн сувилалд 50 хувийн хөнгөлөлттэй сувилуулдаг. 2024 оны байдлаар ахмадын зориулалттай амралт, сувилалд гэхэд 50 мянга орчим ахмад настанд 15 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Энд ахмад настан өөрөөсөө 70 мянган төгрөг төлөөд, халамжийн сангаас 280 мянган төгрөг төлөөд долоо хоног амарч сувилуулдаг.

Нөгөө талаасаа рашаан сувилал буюу яг дотоодын рашаан сувилалд амарч сувилуулсан тохиолдолд тухайн ахмад настны нийт зардлынх нь 50 хувийг халамжийн сангаас зарцуулдаг.

Энд 49 мянган хүнд 7.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Үүнээс гадна ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд 2024 он... /минут дуусав/

Х.Баасанжаргал: Нэмж хариулах уу? 5 дугаар микрофон.

В.Рэнцэнханд: Ер нь ахмад настны тоо жилээс жилд нэмэгдэж байгаа.

2025 онд 385 мянган ахмад настан байсан бол одоо ингээд 415 мянган ахмад настан болсон.

Тэгэхээр энэ хамрагдаж байгаа хүний тоо ч гэсэн жил болгон нэмэгдэж байгаа. Одоо яг энэ нийт ахмад настанд хөнгөлөлт тусламжид зарцуулж байгаа зардлын 50 гаруй хувийг нь зөвхөн амралт, сувилал, рашаан сувилалд зарцуулж байна.

Тэгээд энэ оны төсөв болон яг л гучин хэдэн мянга, тавин хэдэн мянга гээд нэмэгдээд явсан байгаа. Сая 2024 оны тоог хэлсэн. 2025 оны гүйцэтгэл одоогоор хараахан гараагүй байгаа. 2026 оны төсөвт 2025 оны төсөвтэй ойролцоо байдлаар тусгасан.

Тэгээд мөн асаргааны хувилбарт үйлчилгээнд тусад нь 5 тэрбум төгрөг тусгасан. Энд төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр ахмад настанд өдрийн асаргаа, үйлчилгээнд, гэрээр очих асаргаа, үйлчилгээ, мөн түр байршуулан асрах гэдэг олон төрлийн асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэхээр хуулийн хүрээнд шинэ журмууд гараад төрийн бус байгууллага хувийн хэвшилтэй гэрээлэн ажиллаж байна.

Х.Баасанжаргал: Ө.Шижир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ө.Шижир: Ахмадын зээлийн тэтгэврийн хүү бууруулахтай холбоотой ер нь нэг талаасаа тэтгэмж л нэмэх асуудал шүү дээ.

Олж байгаа орлого нь амьдралынх нь зардалд хүрэхгүй байгаа учраас зээл авч байгаа. Тэгээд 24 сар гэж нэг үйлийн үртэй сар байна.

24 сар гэдгийг хаанаас гарсан шинжлэх ухааны үндэстэй тоо байдаг юм гэдгийг асуумаар байгаа юм. Арилжааны банкнууд нь 24 сар гэдэг. Сангийн яам нь ахмадууд нь насаараа төрд ажиллачхаад гавьяаныхаа амралтад гараад нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэвэр тэтгэмжээ авах гэхээр дахиад 24 сарын дотор хоёр хувааж өгнө гээд Сангийн яам нь үздэг.

Тэгээд энэ 24 сар гээд зүгээр бодоод олсон тоо байдаг юм уу, эсвэл шинжлэх ухааны үндэслэлтэй тоо байдаг юм уу гэдгийг асуух гэсэн юм.

Би өмнө нь ч хэлж байсан юм. Б.Жавхлан сайд та өөрөө тэтгэвэрт гарахгүй юу гээд. Тэгээд үүнтэй холбоотой ер нь яг ний нуугүй хэлэхэд энэ чинь хүний л амьдрал юм чинь олон юм тохиолдоно. Амьдрал чинь өөрөө олон өнгөтэй шүү дээ.

Зүгээр энгийнээр хэллээ гэхэд 4 хүүхэдтэй ахмад байлаа гэж бодоход тэр хүн чинь зээл аваад ч юм уу, эсвэл тэр нэг удаагийн тэтгэмжээрээ амьдралд арай тааруухан явж байгаа хүүхдэдээ нэг тус дэм юмсан, орон байрных нь урьдчилгаанд өгөх юмсан, ядаж машин аваад өгөх юмсан гэж л бодож зээл авдаг юм байна лээ шүү дээ.

Тэгээд тэрийг нь манайхан авангуутаа үр хүүхдүүд нь аваад хэрэглэдэг гэдэг байдлаар нэг талаас нь яриад байгаа юм.

Ер нь тэгээд ихэнх тэтгэвэр авч байгаа хүмүүс тэр хүүхдийнх нь нэг байрны урьдчилгааг нь шийдэж өгдөг ч юм уу, эсвэл машиныг нь шийдэж өгдөг ч юм уу ингээд л нэг яадаг юм. Баян тансагтаа тансаглаад байгаа юм нэг ч байхгүй. Ер нь бол. Тэтгэвэр аваад тэтгэврийн тэтгэмжээрээ тансаглаад үрэн таран хийдэг хүн нэг ч байхгүй гэдгийг би хэлэх гэсэн юм.

Тэгээд нэг юм тэтгэмжээ аваад тэтгэвэртээ гараад зээл авах гэхээр банк нь аваачаад 24 сар гээд дахиад тавьдаг. Яг юунаас авсан тоо юм бүү мэд.

Тэгэхээр үүнийг ер нь хармаар байгаа юм. Тэгээд төр нь 24 сар, арилжааны банк нь 24 сар. Ингээд 48 сараас илүү та нар байхгүй шүү дээ гэж үзээд байгаа юм шиг нэг ийм логикийн зөрчил үүсээд байгаа юм.

Тэгээд би өмнө нь Т.Аубакир сайдад ч хэлж байсан, яамдад ч хэлж байсан. Наад тэтгэмж чинь хоёр хувааж өгөх юм бол Өв залгамжлалын хуулиар үйлчлэхгүй шүү гэдгийг нь би биечилж уулзаж хэлсэн.

Яагаад гэвэл Өв залгамжлалын хууль чинь өөр байна гээд. Тэгээд дараа нь үр хүүхдүүд нь өвлөгддөг боллоо гэж Пи Ар хийсэн. Чүү амьд үлдсэнд нь баяр хүргээд байгаа юм уу, яагаад байгаа юм? Үр хүүхдэд нь гээд.

Төр нь өөрөө ахмадыгаа доромжлоод байдаг. Санаа амар бурхны оронд. Одоо арай ч үр хүүхдүүд чинь үлдсэн тэтгэмжийг чинь хувааж өгнө өө гэдэг байдлаар хандаад байгаа юм уу. Төр нь өөрөө ийм хөндий, хүйтэн хандаад байна шүү дээ.

Тэгээд би ёстой муухай ч гэсэн ганцхан асуулт асуужа. Нэгэнт 24 сар ярьсных.

- ▶ 24 сарын дотор тэтгэвэртээ гараад, зээл аваад бурхны оронд одсон хичнээн ахмад байдаг юм? Энэ тоо.
- Зээл аваад нэг.
- Тэтгэврийн зээл аваад нэг.
- Тэтгэвэртээ гараад бас нэг.

Ингээд энэ 24 сарын дотор. 24 сар гэдэг л нэг учиртай тоо байх шиг байна. Тэгээд нэг ийм л ганц асуулт асуух гэсэн юм.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

В.Рэнцэнханд: Гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул.

Тэтгэврийн зээлийн олгох хугацаа 24 сар гэдгийг яамнаас тогтоогоогүй. Банкуудаас тогтоож байгаа. Арилжааны банкууд харилцан адилгүй хугацаа тогтоож байсан.

Тэтгэврийн зээлийг тэглэсний дараа тэтгэврийн зээлийн хугацаа 12 сар байх тийм зохицуулалт байсан.

Энэ зохицуулалт байхгүй болсон. Ингэсэнтэй холбогдолтойгоор 2023 оны эцсийг хүртэл 12 сарын хугацаатай тэтгэврийн зээлийн хэмжээг банкуудын хооронд өрсөлдөөн үүсэх замаар 24 сар болгосноор тодорхой банкууд жишээлэх юм бол Голомт гэх мэт банкнууд анх 24 сар болгосноор тэтгэвэр авагчид банкаа солих үзэгдэл их гарсан. Яваандаа өрсөлдөөний улмаас бүх банкууд 24 сар болгосон.

Тэгэхээр яг 24 сарыг яагаад болгосон гэдэг нь банкууд илүү хариулах нь зүйтэй байх.

Ер нь эрэлт хэрэгцээн дээрээ үндэслэсэн байх. Нөгөө талаасаа Сангийн яам тэр 24 сар гэдэг асуудлыг манай яамнаас санал аваагүй. Зарчмын хувьд

ингэж тэтгэвэр авагчийн тэтгэврийг удаан хугацаанд олгох эсэх асуудлаар албан ёсны байр суурь яам өгөөгүй байгаа. Тэгээд үүнийг Сангийн яам илүү тайлбар өгөх байх.

Үндсэн асуудал юу вэ гэхээр тэтгэвэр гэдэг бол тухайн хүний насаараа төлсөн шимтгэлийн үр шим. Тэтгэврийн үндсэн зорилго тухайн даатгуулагчийн хэрэглээг smooth буюу зөөлөн байдлаар ажил, хөдөлмөр эрхэлж байх үедээ хүн ямар хэрэглээтэй байсан, тэтгэврийн насанд гарсан хойноо огцом хэрэглээг унагахгүйгээр тэр хэрэглээг аажим хадгалах зорилго байдаг.

Хэдийгээр ажил, хөдөлмөр эрхэлж байх үеийнхээс хэрэглээ үндсэндээ буурсан ч гэсэн.

Тэгэхээр энэ хэрэглээгээ хүн өөрөө л хангах ёстой. Үүнийг бусдад зориулах алба байхгүй. Одоо банкуудтай бид олон удаагийн уулзалт, ажлын хэсгийн хүрээний үүднээс гэсэн уулзаж байхад ахмадуудад хамгийн тулгарч байгаа асуудал нь өрийн сүлжээнд орчхоод байна. Өөрөөр хэлбэл ерөөсөө нэг ч хоног гар дээрээ тэтгэврээ авалгүй 2 жил, 3 жил болсон ахмадууд байна.

Тэгэхээр зээлээ төлөхийн тулд л зээл авах маягаар яваад байгаа нь өрийн сүлжээнд орсон байна. Энэ бол ахмадуудын хувьд асуудал байна. Тэгэхдээ хэрэглээг шууд хүчээр хорих замаар энэ асуудлыг шийдэхгүй гэдэгтэй санал нэг байгаа. Илүү уян хатан байдлаар.

Нөгөө талаас энэ хэрэглээний зээлийг яагаад их авч байна гэхээр бүх төрлийн хэрэглээний зээл дээр зорилго асуудаг, нотлох баримт асуудаг. Энэ юунд зарцуулах гэж байгаа хэрэглээг нь шалгадаггүй. Тийм ээ. Ийм зүйл байгаа.

Тэгээд ахмадуудаас бид энэ зээлийг өөрчилснөөр маш их хэмжээний гомдол ирсэн. Ямар гомдол ирсэн бэ гэхээр энэ тэтгэврийн мөнгө миний мөнгө учраас үр хүүхдэдээ өгмөөр байна. Би үр хүүхдэдээ өгмөөр байна. Би үр хүүхдэдээ өгөх нь миний асуудал гэдэг байдлаар маш их хэмжээний гомдол ирсэн.

Гэхдээ бодит амьдрал дээр ахмадууд 24 сарын хугацаанд гар дээрээ орлогогүй байх нь амьжиргааны маш өндөр эрсдэл дагуулж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ дээрээ нэмэлт тусламж, үйлчилгээ авч чадахгүй болдог. Ингээд ирэхээр дахин зээл авах магадлал руу улам их турхираад байна. Өрийн сүлжээ байгаад байна.

Тийм учраас хэрэглээг нь огцом хорьдоггүй юм гэхэд илүү хугацаа болон хэмжээ, өр орлогын харьцааг аажим шилжүүлэх нь зүйтэй байгаа юм. Тэгээд өр

орлогын харьцааг авснаараа богино хугацаанд нийт ахмадын зээлийн үлдэгдэл огцом нэмэгдсэн гэсэн мэдээллийг Банкуудын холбооноос бидэнд өгсөн.

Одоогоор тэтгэврийн зээлийн асуудлыг зохицуулсан ямар нэгэн эрх зүйн баримт бичиг байхгүй байгаа.

Х.Баасанжаргал: Ө.Шижир гишүүн тодруулах уу? Тодруулаад 1 минутаа авах уу? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: Тийм. Яг зээлтэй тэтгэвэр авагчдын тоо манай яаманд байхгүй.

Ерөнхийдөө зээлийн мэдээлэл хувь хүний нууцын тухай мэдээлэлд орж байгаа учраас банкууд л хариуцаж байгаа. Тэгээд энэ мэдээллийг ажлын хэсэг банкуудаас бүгдийг нь авсан.

Ер нь зээлтэй байж байгаад тэтгэврийн нас, дундаж нас буюу тэтгэвэр тогтоолгож байгаа нас дунджаар 55, 60 байгаа.

Тэгэхээр 55 болон 60 насандаа монгол хүний дундаж нас баралтын тэр магадлалаараа тэгээд зээл авч байгаа хувиасаа л болох байх. Яг ямар банкуудад ямар хувьтай байгаа гэсэн мэдээлэл манай яамд аваагүй. Үүнийг банкуудаас аваад бид танд бичгээр илгээх боломжтой.

Х.Баасанжаргал: С.Эрдэнэбат гишүүнээс нэмэлт хариулт.

С.Эрдэнэбат: Ө.Шижир гишүүний асуултад банкуудаас асуусан. Ажлын хэсгийнхэн.

Ер нь нийт ахмадуудын 67 хувь нь тэтгэврийн зээлтэй байдаг. Тэтгэврийн зээл авчхаад нас барсан ахмадуудын үндсэндээ бараг 80 хувь нь гэсэн байх. Би тэр тоог тодруулж өгье.

Үлдэж байгаа хүмүүс нь буюу гэр бүл хамтран зээлдэгч гэдэг хүнийг давхар авч байгаа шүү дээ. Тэр хүмүүс нь буцаагаад төлдөг гэж байгаа юм. Бас нэг талаараа зээлийн соёлтой. Харьцангуй хариуцлага өндөртэй буюу манай ахмадууд түүний хамтран зээлдсэн хүмүүс нь эцэг, эх хүмүүсээ өртэй хорвоогийн жам ёсыг өнгөрүүлэхгүй гэдэг үүднээсээ буцааж төлдөг нь дийлэнх нь.

Тэр нарийн мэдээллийг нь өөрт чинь өгье. Яг надад одоо алга байна. Тийм.

Х.Баасанжаргал: Нэмэлт тодруулга. Ө.Шижир гишүүн.

Ө.Шижир: Яагаад асуугаад байна вэ гэхээр зээл нь өвлөгддөг. Зээл нь өвлөгдөөд үлдэж байгаа шүү дээ. Хамтран зээлдэгчид нь ч юм уу. Тэгсэн мөртлөө ахмадынх нь тэтгэвэр, тэтгэмж нь өвлөгддөггүй байсан байхгүй юу даа.

Тэрийг би чуулган дээр хэлж байсан шүү дээ. Наад Өв залгамжлалын хуулиар 24 сар болгох юм бол тэтгэврээ авсан ахмадын чинь тэтгэмж нь өвлөгдөхгүй юм байна шүү. Өв залгамжлах хуулиар. Яагаад гэвэл бий болоогүй хөрөнгө учраас наадах чинь Өв залгамжлагчийн хуулиар өвлөгдөхгүй юм байна гэдгийг би Т.Аубакир сайдад хэлж байсан юм.

Тэгсэн саяхан өвлөгддөг боллоо гээд Засгийн газар нь Пи Ар хийж байна лээ. Баяртайгаар Пи Ар хийж байна лээ шүү. Энэ чинь одоо юу гэсэн үг юм бэ.

Тэгээд миний асуугаад байгаа юм нь тэтгэврээ аваад. Тэгвэл танай дээр ийм тоо байх ёстой. Тэтгэврээ аваад, тэтгэвэртээ гараад 24 сарын дотор хичнээн ахмад бурхны оронд оддог юм бэ гэж.

Яагаад гэхээр энэ тоонуудыг чинь харьцуулж харах гээд байна шүү дээ.

- Ямар үндэслэлтэй 24 сар юм.
- Ямар үндэслэлтэй зээлийн хүү байдаг юм –

-гэдэг чинь энэ тоонууд дээр харагдах юм болов уу л гэж асуугаад байгаа юм.

Х.Баасанжаргал: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Л.Мөнхзул: гишүүний асуултад хариулъя. Л.Мөнхзул.

Ер нь энэ тоо манайхаас гарах боломжтой. Жилд дунджаар 15 мянга орчим тэтгэвэр авагч нас бардаг. Бүх төрлийн тэтгэвэр авагч нар.

Одоо нийгмийн даатгалын санд хамгийн эрт тэтгэвэр тогтоолгосон хүн 1976 онд тэтгэвэр тогтоолгосон хүн байгаа.

Тэгэхээр үндсэндээ өөрөөр хэлбэл 49 жил тэтгэвэр авч байгаа гэсэн үг. Хамгийн удаан тэтгэвэр авч байгаа хүн.

Тэгэхээр Та нэг жил тэтгэвэр аваад 2 жил тэтгэвэр авч байгаад нас барсан нийт даатгуулагчийн тоог хүсэж байна. Тэгээд бид үүнийг хүйсээр нь болон задаргаагаар нь гаргаад танд маргааш гэхэд өгөх боломжтой.

Х.Баасанжаргал: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо Иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдлүүдийн шийдвэрлэлтийн талаар санал хураалт явуулж эхэлье. Манайх санал хураалт явах боломжтой байна уу. Байнгын хорооныхон. Ирц яаж байна.

Би ажлын хэсэгт нэг санал хэлэх гэсэн юм.

Нийтдээ энэ ирсэн өргөдлүүд 4 багц өргөдөл байгаа юм. Тэрний хамгийн сүүлийн багц буюу тэр асаргааны үйлчилгээтэй холбоотой өргөдөл дээр ерөөсөө манай Байнгын хороо ирсэн материал дотор ахмад настны асаргааны үйлчилгээтэй холбоотой төрийн барьж байгаа бодлогын талаар ямар ч мэдээлэл ирээгүй шүү. Манай яамныхан. Ажлын хэсгийнхэн. Тэрийг анхаарахгүй бол. Эрүүл мэндийн яам.

Энэ ирсэн өргөдлийн 4 дэх багц нь ахмадын асаргааны асуудалтай холбоотой өргөдөл ирсэн байхгүй юу. Түүнтэй холбоотой ерөөсөө дорвитой шийдэл, дорвитой бодлого гэхээр материал ерөөсөө манай Байнгын хороонд ирээгүй.

Тийм учраас би яг энэ өргөдлийг хаахгүй үргэлжлүүлээд, ялангуяа асаргааны асуудалтай холбоотой асуудал дээр ажиллах ёстой гэж харж байгаа. Тэгээд Эрүүл мэндийн яам байна, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам байна. Тэгээд асаргаага бид дотор нь дахиад хоёр ангилмаар байгаа байхгүй юу. Бүр асрамжийн төвийн үйлчилгээ, тэгээд амралт сувилал, дахиад өөр бусад ямар хувилбарт асран хамгааллын үйлчилгээнүүд байх вэ гэдэг дээр гишүүдийн гар дээр ирсэн материал дотор ерөөсөө асран хамгаалалттай холбоотой, асаргаатай холбоотой материал бүрэн ирээгүй байсан. Бараг төр бодлого байгаа юм уу л гэмээр юм байсан шүү.

Тэгэхээр тэрийг манай ажлын хэсгийнхэн анхаараад, тэгээд цааш нь материал, юмаар гишүүдийг мэдээллээр хангаарай гэж хүсэх гэсэн юм.

Санал хураалтаа үргэлжлүүлье.

Ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэндийн болон асрах үйлчилгээг сайжруулах гээд яг энэ багцыг хэлээд байгаа гэсэн үг. Тийм ээ. Ахмадуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, шаардлагын дагуу ажиллагаа хийгдсэн тул өргөдөл гаргагчдад хариу хүргүүлэх асуудлыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад гишүүд бэлтгэе. Санал хураалт явуулъя. Болж байна уу? Гишүүд санал хураалтад бэлтгэе. Бүгдээрээ санал хураалт.

Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувь нь зөвшөөрсөн учраас санал хураалт дэмжигдлээ.

Хүрэлцэн ирсэн ажлын хэсэгт баярлалаа.

Гишүүд. Дараагийн өргөдлүүд Хувь хүний хувийн мэдээлэлтэй холбоотой өргөдлүүд байгаа учраас Байнгын хорооны хуралдааныг хаалттай горимоор явуулах шаардлагатай гэж үзэж байгаа учраас хуралдаан даргалагчийн зүгээс горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Хаалттай горимоор явуулах гэдгээр санал хураалт явуулъя гэсэн үг.

Санал хураалт. /алх цохив/

Хураалт хаалттай горимоор хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор 56.3 хувь нь дэмжсэн учраас хаалттай горимд шилжүүлье.

Тэгээд бэлтгэлийг холбогдох Их Хурлын Тамгын газрынхан хийхийг хүсье. 5 минут болох уу. Тийм ээ.

Хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 17 цаг 47 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД